

ЭНХТЭГ ӨГҮҮЛЭЛ нь зохиогчийн үзэл баримтлал болно.

## "ГАДААД МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛЫН НУУЦ ҮГСЭЛ" НОМЫН ТУХАЙ ШҮҮМЖ

"Гадаад монголын тусгаар тогтнолын нууц үгсэл" /Вай Мэнгу дули нэйму/ номыг "Ардын Хятадын хэвлэлийн газар" 1994 оны 4-р сард Бээжинд 50000 хувь хэвлэжээ. 480 тал хуудастай, газрын зураг хоёртой, 11 гэрэл зурагтай. Номын бөгсөнд Чжан Гоань, Сун Дачуан, Ван Синьгуа, Чэнь Юнган, Чжан Хуйцзюнь, Ши Кэцань, Ду Цзиган, У Цэян, Чжу Хуачжан, Ма Чжунху, Ду Сяоань, Сян Ли зэрэг зохиох, редакторлахад оролцсон гэжээ.

Энэ бол БНМАУ /Монгол Улс/-ын тусгаар тогтнолыг үстгаж, БНХАУ-д нийлүүлэх БНХАУ-ын төрийн стратегийн хагас далд бодлогыг хэрэгжүүлж дүүсгахад хятадын ажил хэрэгч хүмүүс, тухайлбал үйлдвэр, худалдааны хүмүүсийг одоогийн зах зээлийн нээлттэй эдийн засгийн шинэ нөхцөл байдалд хөөргөн өдөөж дайчлахад чиглэгдсэн ном мөн болох нь дор дурьдсан баримтаар нотлогдож байна. БНХАУ бол нийгмийн сэтгэл судлалын /психологийн/ нэн эртний уламжлалтай цөөн орны нэгэн билээ. 1958-1960 оны "Их үсрэлт", "1966 оны 5-р сараас 1976 оны 10-р сар хүртлэх "соёлын хувьсгал" гэх мэтийн тэрбум хятад ард түмнийг хөөргөн хөдөлгөж бараг дэлхий дахиныг донсолгосон үйл явдал бол энэ уламжлалын бодит тод илрэл мөн. Энэ ном бол агуулгаараа барахгүй хэлбэрийн хувьд Монгол улсын тусгаар тогтнолын эсрэг үлгэрлэвэл нэг ёсны "соёлын хувьсгал" хийх гэж байгаа бүтээл болжээ. Хэлбэрийг үзсүгэй. Номын бүтэн тал цаасаар нугалан хийсэн нүүрний дээд талд номын нэрийг томоор тавихдаа хар дөрвөлжин дотор "нууц үгсэл" /нууц хуйвалдаан/ гэдгийг нь цагаанаар хэвлэн дараа нь номын гол агуулгыг долоон том хар цэг тавин 7 зүйлд багтаан өгүүлээд доод хэсэгт нь БНМАУ-ын газрын зураг дотор хүндэт харуулын өмнүүр Брежнев, Цэдэнбэл хоёр явж байгаа гэрэл зураг тавьж,

хагас нугалаас цаасанд Монголын газрын зургийн тоймыг малын зурагтай байрлуулжээ.

Хавтасны дараах хоёр нүүрэнд ногоон дэвсгэрт цагаанаар номын нэр, 7 зүйл агуулгыг хэвлэсэн байна. Номын эхэнд Сүхбаатар, Чойбалсан, Засгийн газрын ордон, Богд, хүндэт харуулын өмнүүр Брежнев, Цэдэнбал хоёрын явж байгаа, Брежнев Цэдэнбалтай хамт авахуулсан зураг зэрэг тавьсан байна.

Номын сүүлчийн хавчуулга хуудасны нүүрэнд 1946 оноос өмнөх өөрөөр хэлбэл Бүгд Найрамдах Хятад Улс Бүгд найрамдах Монгол ард улсыг зөвшөөрөн дипломат харилцаа тогтоохоос өмнө Хятадын газар нутаг, Монголын чуулган, хошуудын зураг, ар талд нь БНМАУ-ын газрын зургийг газарзүйн солбицолтой тус тус хийгээд номын ар нүүрэнд Монголын газрын зургийн хагасыг тэмээ мал бэлчиж байгаагаар харуулсан гэрэл зураг тавьжээ. Энэ бүхнийг ажил хэрэгч хятад хүмүүс хараад яах вэ? гэдэг нь мэдээж.

Номын агуулгыг илтгэсэн номын нүүрний ба доторх гарчигийг нийгмийн сэтгэл судлалын шинжлэх ухааны орчин үеийн дээд түвшинд хийсэн нь маш оновчтой товчхон нэр, тооноос нь тодорхой харагдана. Номын нүүрний агуулгын томъёог нь: 1. Гадаад Монголын ван гүн нарын тоглосон "тусгаар тогтнол" бузар жүжгийг Цагаан хаант Орос дэглэсэн нь. Амьд бурхан Жавзандамба биеэ худалдан урваж, Чойбалсан Зөвлөлт Оросоос тусламж авахаар нууцаар одсон нь; 2. Лениний зарлигаар улаан цэрэг Гадаад Монголд орсон нь; 3. Гадаад Монголын бүрэн эрх Хятадад харьяалагдахыг Зөвлөлт Орос улс хүлээн зөвшөөрсөн нь; 5. Мао Цзэдун Москвагийн уулзалтан дээр хүчлэн зүтгэсэн нь; 6. Бээжингийн хэлэлцээн дээр Хрущев үгслээ хүлээхгүй цааргалсан нь; 7. Чжоу Энлай хүчин мөхөсдөн тэнгэр ширтэж, санаа алдсан нь гэж байна. Үнэхээр хятад хүний зүрхийг догдлуулсан сэтгэлийг хөөргөж чадахуйц болжээ. Номын зөвхөн гарчиг нь таван хуудас арван бүтэн нүүр эзэлсэн 10 бүлэг, 57 зүйл, 161 дэд зүйлийн нэр байна. Хятад хүмүүст нөлөөлөх энэ номын бас нэг чухал тал бол зуу гаруй мөр шүлгийг зохих газар маш оновчтой хэрэглэх эх заалгүйгээр олон баримт дурьдан уран

Монголын сайхан хэлээр бичсэн явдал мөн. Харваас шүлэг танигдахаар ялгаруулан тавьсан 120 мөр шүлэг байна, мөн "Хятадын умарт хил хязгаар Гадаад Монгол" гэдэг нэгдүгээр бүлгийн эхлэл болох "Уудам талын байдал" 1-р бүлэгд Монгол улсын сүрлэг сайхан байгаль зэргийг дүрсэлсэн бүгд 44 мөр шүлэг, мөн бүлгийн 2-р зүйлийн "Талын сан хөмрөг үнэхээр баялаг" гэдэг Монгол улсын байгалийн баялагын арвиныг магтсан 1-р дэд зүйлд 20 мөр шүлэг, "Ховдог шунахай цагаан баавгай" гэдэг 2-р бүлгийн эхлэлт болох "Гай гамшгийн эх булаг Дорно зүг айсуу" гэх бусад улсыг муу муухай дүрсэлсэн ердөө бүтэн тал хуудас 1-р зүйлд 17 мөр шүлэг, ингээд 1-р бүлэгт 64 мөр, 2-р бүлэгт 39 мөр, бүгд 103 мөр шүлэг хэрэглэж, үлдэх 10 гаруй мөр шүлгийг 4,5,6-р бүлгийн онцлог газарт ашигласан байна. Жишээлбэл, "Их эзэнт улсын зүүдээ дахин зүүдэлсэн нь" гэдэг Монголын ардын хувьсгал ялахын өмнөх, ялсны дараах 1924 оны үеийг хамарсан 5-р бүлгийн 1921 оны 7-р сард Монголд ардын хувьсгал ялсны үр дүнд Монголын ард түмэн эрх чөлөөт тусгаар тогтносон улсаа байгуулсанд хятадууд хорсон занасан байдлыг илтгэсэн "Уйлж унжсан Хятад орон" гэдэг 12-р зүйлийг эхлэхдээ "Хятад үндэстэн орчин үеийн түүхэндээ их гүрэнд доромжлуулан, уудам сайхан эх нутгаа цагаан оросын засгийн газрын шулманд бүхэлд нь залгилуулсаар байв. Гадаад Монголын салан тусгаарласан нь Хятад улсын үзэсгэлэнт сайхан хайтан цэцгийн модны навчтай адил нутаг дэвсгэрээс үлдсэн умарт талд хортон шавьж хорхойд идэгдэн өмөрсөнтэй адил нэгэн асар том онгорхой гарлаа" гэх мэтээр дурьдаад:

Ээ! Үзэсгэлэнт сайхан хайтан цэцэг минь

Час улаан хайтан цэцэг минь

Цэвэр анхилуун гоёхон хайтан цэцэг минь

Хүний сэтгэлийг уургалан татах хайтан цэцэг минь

Үзэсгэлэнт сайхан хайтан цэцэг минь намрын салхинд хуйлран уналаа! гэж /238-239/ Монголд ургадаггүй, Хятадад ургадаг хайтан цэцгээр шүлэглэсэн нь хятад хүний сэтгэлийг хөдөлгөж чадна. Ингээд "үзэсгэлэнт сайхан хайтан цэцгэн навч маань бүтэн биш боллоо доо" гэж 12-р зүйлээ төгсгөсөн нь хятад хүний дотрыг арзасхийлгэх нь мэдээж!

Хятадын харгис хүчин ч, Сун Ятсен мэтийн ардчилсан хувьсгалт хүчин ч их хан үндэстний дээрэнгүй үзэл баримтлан БНМАУ-ын биеэ даасан төр ёсны 2000 гаруй жилийн уламжлалыг Хятад сурвалж бичгийн мэдээг үл хайхран санаан дураар үгүйсгэж, БНМАУ-ын тусгаар тогтнолд өнгөлзсөөр ирсэн билээ. Хятадын хан үндэстний дээрэнгүй үзэлтнийг залуу зөвлөлт засгийн зүтгэлтэн хүртэл бүр 1922 онд шүүмжилж байжээ. Японы эрдэмтэн Ф. Исоно бичсэнээр "Мөн 1921 оны 1-р сард Алс Дорнодын хөдөлмөрчдийн их хурал дээр Зиновьев өмнөд хятадын хувьсгалт удирдагчдын дунд хүртэл "Монголыг Хятадын захиргаанд эргүүлэн авах харгис этгээд" байгааг шүүмжилсэн байдаг. Хятадын коммунист нам ч гэсэн 1922 оны 7-р сард болсон намын 2-р их хурлаас Монгол, Төвд, Шинжаныг хятадын холбооны улсад багтах "Автономит улс" гэсэн байр суурийг тодорхойлохоос ахисангүй" байна /15-ын 49/.

Бүгд Найрамдах Хятад улс /1912-1949/ нь Монгол Ардын хувьсгал 1921 оны 7р сарын 1 Индялсан анхны өдрөөс эхлэн БНМАУ-ын эсрэг өргөн цартай дайсагнасан ажиллагааг явуулсаар ирсэн юм.

БНХАУ-ын удирдагч Мао Цзэдун, Чжоу Энълай нар БНМАУ-ыг Хятадад нийлүүлэх Чан Кайшигийн Хятадын бодлогыг өвлөн авч, улмаар БНХАУ-ын төрийн хагас далд стратегийн бодлого болгож, түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө БНХАУ албан ёсоор тунхаглагдаагүй байх үеэс эхлэн маш шургуу ажилласаар байжээ. Мао Цзэдун нар энэ стратегийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд БНМАУ-ыг тусгаар тогтнолыг устган Хятадад нийлүүлэх асуудлыг Зөвлөлт Холбоот Улсын удирдлагад тавихын зэрэгцээ энэ бодлогыг биелүүлэхэд хятадын ард түмнийг бүрэн дайчлахад чиглэгдсэн ажиллагааг БНХАУ-ын дотор илэрхий явуулсаар байсан боловч, уг бодлогоо БНМАУ-ын удирдлагаас нууж, БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүндэтгэж байгаа мэт дүр үзүүлэн монголын ард түмнийг мэхэлж байсан учир "БНХАУ-ын төрийн хагас далд стратегийн бодлого" гэж нэрлэв.

Хятадын харгис хүчин ч, Сун Ятсен мэтийн ардчилсан хувьсгалт хүчин ч их хан үндэстний дээрэнгүй үзэл баримтлан БНМАУ-ын биеэ даасан төр есны 2000 гаруй жилийн уламжлалыг Хятад сурвалж бичгийн мэдээг үл хайхран санаан дураар үгүйсгэж, БНМАУ-ын тусгаар тогтнолд өнгөлзсөөр ирсэн билээ. Хятадын хан үндэстний дээрэнгүй үзэлтнийг залуу зөвлөлт засгийн зүтгэлтэн хүртэл бүр 1922 онд шүүмжилж байжээ. Японы эрдэмтэн Ф. Исоно бичсэнээр "Мөн 1921 оны 1-р сард Алс Дорнодын хөдөлмөрчдийн их хурал дээр Зиновьев өмнөд хятадын хувьсгалт удирдагчдын дунд хүртэл "Монголыг Хятадын захиргаанд эргүүлэн авах харгис этгээд" байгааг шүүмжилсэн байдаг. Хятадын коммунист нам ч гэсэн 1922 оны 7-р сард болсон намын 2-р их хурлаас Монгол, Төвд, Шинжаныг хятадын холбооны улсад багтах "Автономит улс" гэсэн байр суурийг тодорхойлохоос ахисангүй" байна /15-ын 49/.

Бүгд Найрамдах Хятад улс /1912-1949/ нь Монгол Ардын хувьсгал 1921 оны 7р сарын 1 Индялсан анхны өдрөөс эхлэн БНМАУ-ын эсрэг өргөн цартай дайсагнасан ажиллагааг явуулсаар ирсэн юм.

БНХАУ-ын удирдагч Мао Цзэдун, Чжоу Эньлай нар БНМАУ-ыг Хятадад нийлүүлэх Чан Кайшигийн Хятадын бодлогыг өвлөн авч, улмаар БНХАУ-ын төрийн хагас далд стратегийн бодлого болгож, түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө БНХАУ албан ёсоор тунхаглагдаагүй байх үеэс эхлэн маш шургуу ажилласаар байжээ. Мао Цзэдун нар энэ стратегийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд БНМАУ-ын тусгаар тогтнолыг устган Хятадад нийлүүлэх асуудлыг Зөвлөлт Холбоот Улсын удирдлагад тавихын зэрэгцээ энэ бодлогыг биелүүлэхэд хятадын ард түмнийг бүрэн дайчлахад чиглэгдсэн ажиллагааг БНХАУ-ын дотор илээр явуулсаар байсан боловч, уг бодлогоо БНМАУ-ын удирдлагаас нууж, БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүндэтгэж байгаа мэт дүр үзүүлэн монголын ард түмнийг мэхэлж байсан учир "БНХАУ-ын төрийн хагас далд стратегийн бодлого" гэж нэрлэв.

Бээжингээс хойш Шицзячжуан хотын дэргэдэх Сибайпо тосгонд байрладаг Мао Цзэдуны штабд зөвлөлтийн төрийн нэгтгэлтэн А.И.Микояныг 1949 оны 2-р сард очиход БНМАУ-ын тусгаар тогтнолыг устган Хятадад нийлүүлэх тухай асуудлыг түүгээр дамжуулан И.В.Сталинд тавьсныг Мао Цзэдуны дэргэд сууж байсан Сталиний бие төлөөлөгч И.В.Ковалев 1990 онд түүхч-хятадач С.Н.Гончаровын асуултанд хариулахдаа дурьджээ /23-ын 86/. И.В.Сталин уг асуудлыг огт зөвшөөрөлгүй, харин 1949 оны 9-р сарын 30-нд Х.Чойбалсанд мэдээлжээ /7-гийн 88/. Үүнээс хойш

Хрушев, Булганин, Микоян нарыг 1954 онд Бээжинд очиход БНМАУ-ыг БНХАУ-д нийлүүлэх тухай асуудлыг зөвлөлт Холбоот Улсын удирдлага шинэчлэгдсэн нөхцөл байдлыг далимдуулан дахин тавихад Зөвлөлтийн удирдлага бас татгалзжээ. Энэ тухай Микоян 1956 оны 2-р сарын 24-нд Ю.Цэдэнбалд мэдээлсэн байна /7-гийн 94/. БНМАУ-ыг БНХАУ-д нийлүүлэх тухай асуудлыг Мао Цзэдунгийн даалгавараар Чжоу Энълай 1954 онд Хрушевт тавихад "нөхөр Чжоу-гийн тавьсан асуудлыг бид хэлэлцэх нь маш хэцүү. Энэ бол Монгол, Хятадын хоорондын асуудал, бидэнд холбогдохгүй. Бид гуравдагч этгээд мөн. Та нар өөрсдөө монголчуудтай биеэрээ уулзан ярилцах нь дээр байхаа?" гэж Хрушев хариулсан гэж Нууц үгсэл номд дурьджээ /415-415/.

БНХАУ-ын удирдагч Мао Цзэдун БНМАУ-ыг БНХАУ-д нэгтгэх тухай асуудлыг Зөвлөлтийн удирдлагад 1949, 1954 онд тавьж байснаас гадна 1964 оны 7-р сард Японы социалист намын төлөөлөгчидтэй уулзахдаа дахин сэдэж байсан түүхийн үнэнийг Ю.Цэдэнбал анх 1980 оны 10-р сард монголын ард түмэн, дэлхий дахинд зарлан мэдэгдсэн "Үнэн" сонин, 1980. 10. 2. №237/ юм. Түүнээс хойш 1981 онд Улаанбаатарт 2500 хувиар нийтлэгдсэн "Түүхийг гуйвуулах маоист аргыг шүүмжлэх нь" номд /17-гийн 19-20 тал/ дурьджээ. Элчин сайд Д.Эрдэмбилэг "Ардын эрх" сонинд /1991.12.26.№229/ нийтлүүлсэн "Улирах цагийг нэхэн бодохын учир" дурсамжиндаа БНМАУ-ыг БНХАУ-д нийлүүлэх тухай асуудлыг Хятадын удирдлага Зөвлөлтийн удирдлагад удаа дараа тавьсаар байсныг хэлсэн юм.

БНХАУ-ын хагас далд стратегийн бодлогоо хэрэгжүүлэхийн тул өөрийн тоталитар системийн механизмыг ашиглан, монгол, хятадын харилцаа, монголын түүхийг гуйвуулах тусгай зохиомол томъёолол-удирдамжыг БНХАУ-ын төрийн байгууллагын нэрээр гаргажээ. "Жэньминь жибао" сонины 1969 оны 10-р сарын 8-ний дугаарт нийтлэн, улмаар орос зэрэг гадаад хэлээр тараасан БНХАУ-ын Гадаад Явдлын Яамны баримт бичигт "Хятад бол 2000 гаруй жилийн өмнө олон угсаатны нэгдмэл улс болсон юм. Чингээд тус оронд феодалын ямарч төр бие биенээ халж байлаа ч гэсэн, ямарч угсаатан захирч байлаа Хятад ертөнц дээр олон угсаатны улс хэвээр оршин тогтносоор ирсэн юм" гэжээ. БНМАУ /Монгол Улс/-ын түүх энэ зохиомол томъёололд огт холбогдохгүй нь хятад, монгол, перс зэрэг хэлний сурвалж бичиг, монгол улсын нутгаас олдсон археологийн дурсгалаар ямарч хөдөлбөргүй бүрэн батлагдсан билээ. Гэвч Хятадын нэлээд түүхчид энэ албан ёсны зохиомол томъёололыг баримтлан Монгол, Хятадын харилцаа, Монгол улсын түүхийг санаан дураар гуйвуулсан асар олон нийтлүүлэн, хятадын ард түмнийг түүхийн талаар төөрөгдүүлэн боловсруулсаар байна. БНМАУ-ын түүхчид монгол, хятадын харилцаа, Монгол улсын түүхийг хятадын хэсэг түүхчин гуйвуулсаар байгааг илчлэн шүүмжилсэн "Түүхийг гуйвуулах маоист аргыг шүүмжлэх нь" зэрэг товхимолыг монгол /17/, орос /25/, англи /37/ хэлээр нийтлүүлсээр байсан юм. БНМАУ-ын түүхчид нь БНМАУ-ын түүхийн бүх үеийг хамарсан "БНМАУ-ын түүх"-ийн гурвалж боть зохиол, "БНМАУ-ын түүх"-ийн нэгэн боть /3 үеийг хэвлэгдсэн/ хэвлүүлснээс гадна ганц сэдэвт олон арван зохиолыг нийтлүүлсэн билээ. Монгол үндэстэн бол 2200 гаруй жилийн төр ёсны уламжлалтай, Хятад улсад огт хамаарагдахгүй биеэ даасан түүхтэй, биеэ даасан ард түмэн мөн болох нь БНМАУ-ын түүхчдийн дээр ерөнхийд нь дурьдсан бүтээлээс тодорхой харагдана.

Гэтэл БНХАУ-ын хэсэг түүхчид нь сурвалж бичгийн мэдээлэл археологийн олдвор баримт, тэр ч байтугай БНХАУ-ын түүхчдийн олон судалгааг үл ойшоон, Монгол-Хятадын харилцаа, Монгол улсын түүхийг эрээ цээргүй гуйвуулах

ажлаа үргэлжлүүлсээр байгаагаар барахгүй БНХАУ-ын төрийн албан ёсны баримт бич игт тусгасаар байна.

1986 онд хятадаар, 1989 оны 11-р сард Өвөр монголын ардын хэвлэлийн хорооноос Хөх хотод монголоор нийтлүүлсэн "Монгол үндэстний товч түүх" бол уг номын 1101 дугаар талд "Дундад улсын эв хамтын намын Өвөр монголын өөртөө засах орны хороо ба Өвөр монголын өөртөө засах орны Ардын зөвлөлийн жолоодлого-хавсрага дор" зохиогдсон гэж бичсэн учир БНХАУ-ын төрийн бодлогыг илэрхийлсэн албан ёсны ном мөн. "Монгол үндэстэн бол эх улсын их гэр бүл доторхи нэгэн урт удаан түүхтэй, ажилч баатарлаг үндэстэн мөн. Тэд урт хугацаагаар манай улсын умарт орны өргөн уудам тал нутагт хөдөлмөрлөж амьдарсаар ирсэн юм. Монгол үндэстэн түүхийн хөгжилтийн явц дунд ялангуяа Монгол улс байгуулагдсны сүүлээр Чингис хаан, жич түүний хойч тейн хэдэн удаагийн алсын аян дайны дунд тал нутгаас гарч явсан монгол хүний ул мөр Европ, Ази хоёр тивийн өргөн уудам газар оронд тархаж, түүнчлэн тэдгээр газарт суурьшиж аажмаар тус орны суугууль ардын бүрэлдэхүүн хэсэг болсон билээ" гээд "13-р зууны анхны жилүүдэд Чингис хаан монгол эл аймгийг нэгтгэж улс байгуулахаас өмнө дундад улсын умар дахины үндэстнүүд өнөөдрийн монгол үндэстний шихилэрэн суусан газарт нэгэнт өнө удааны түүхтэй, болсон юм. Энэхүү газар орны хуучин чулуун зэвсгийн үеийн суугууль ард Шан улс, Чжоу улсаас Чуньцүгийн үеийн өдий төдий овог төрөл буюу аймаг бүлэг, ялангуяа Цинь улс, Хан улсын үеийн Хүннүгээс Тан улс, Сун улсын үеийн умар дахины олон нүүдэлчин үндэстний ажиллагаа нь монгол үндэстний түүхэн хөгжилтөд цөм нөлөө үзүүлсэн юм" гэх /10-ын 1-3/ мэтээр Монгол улсын нутаг, түүний түүхийг Хятадын түүхийн хавсрага болгон өгүүлсээр Монгол улсын биеэ даасан түүхийг санаан дураар үгүй болгожээ.

Хятад, Монгол зэрэг сурвалж мэдээг гуйвуулсан энэ мэтийн судалгааны үр дүнг БНХАУ-ын төрийн зөвлөлийн хэвлэлийн газраас Түвдийн асуудлаар 1992 оны 9-р сард дэлхийн олон улсад тараасан БНХАУ-ын албан ёсны баримт бичигт тусган, БНХАУ-ын төрийн албан ёсны бодлогын

хэмжээнд тавьсан, Үүнд: "Монгол аймгуудын толгойлогч Чингис хаан 13-р зууны эхэнд Хятадын умарт хязгаарт Монголын хаант улс байгуулсан юм... Монголын хаан 1271 онд Юан улсыг тунхаглаад, 1279 онд бүх Хятадыг нэгтгэж дуусгасан билээ. Ингээд Хятадын нутаг дэвсгэр дээр оршин сууж байсан бүх ард түмнийг Хан улс /МЭӨ 206-МЭ 200 он/. Тан улсаас хойш төв засгийн захиргаанд нэгтгэсэн бас нэг төвлөрсөн эзэнт улсыг байгуулсан юм" гэсэн /24-н 2/ ердөө хоёр өгүүлбэрт: а/. Чингис хаан их Монгол улсыг байгуулсан үндсэн газар болох одоогийн Монгол улсын нутаг бол Хятадын нутаг мөн; б/. Монгол улсын нутаг бол Хан /МЭӨ-206-МЭ 220/ улсын нутаг мөн; в/. Монгол улсын нутаг бол Тан улсын /618-907/ нутаг мөн; г/. Монгол улсын нутаг бол Юан /1271-1368/ улсын үеийн Хятадын нутаг мөн мэт болгосон дөрвөн гол дүгнэлтийг багтаажээ.

Нууц үгсэл номын зохиогчид нь номынхоо нэгдүгээр бүлгийг /6-19/ БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн 1992 оны 9-р сарын албан ёсны тэр баримт бичгийг баримтлан "Хятадын умарт хил хязгаар-Гадаад Монгол" гэж нэрлээд, түүний нэгдүгээр зүйлийг "Уудам талын байдал" гэж гарчиглаад "Хятадын уудам нутгийн яг умарт хэсэг нь хөндлөлдөн үргэлжилсэн уулархаг нүд алдам өргөн уудам монголын тал нутаг юм. Энд нэгэн энгүй уудам баян тансаг үр шимтэй нутаг байдаг, тэр бол өнгөрсөн үед хятад хүмүүс Гадаад Монгол гэж нэрлэж дассан одоогийн Бүгд Найрамдах Монгол Ард Улс мөн" гээд /6/ 1-р зүйлийн зургаахан тал хуудсанд Монгол орны нутаг, аж байдлын баялаг, сонин сайхныг дүрслэн бичээд нийтдээ 40 гаруй мөр шүлгээр магтан зурагласан нь хятад хүмүүс, ялангуяа хятадын ажил хэрэгч хүмүүс, худалдаа, үйлдвэрийн хүмүүсийн дурь нь үнэхээр булаан, сэтгэлий нь хөдөлгөн жигүүрлэхээр болжээ.

Нэгдүгээр бүлгийн хоёрдугаар зүйлд "Монголын тал нутгийн анхны нүүдэлчид бол Хүннү хүмүүс юм. Тэд өөрсдэдээ /хятадын/ Ся /улс/-ын хүмүүсийн удам гэж өөрсдөө нэрлэдэг" гэж /12/ Хятадтай нэгэн удамын хүмүүс гэж өөрсдөө хүлээсэн мэт болгон хятад сурвалж бичгийн мэдээг гуйвуулж, Хятадын цөөн тоот үндэстэн байсан мэт болгожээ. Хүннү нарт холбогдох хятад сурвалж

Домгийн мэдээг түүвэрлэн нэгтгэсэн хоёр боть эмхтгэлийг үндэстэнд эртний хятадын түүхчин Сыма Цянь /МЭӨ 145 оны орчим-МЭӨ 86 оны орчим/ өөрийн "Түүхийн тэмдэглэл" зохиолд хүннүү нарыг хятадын домгийн хааны удам гэж сурьдсан /30-ийн 1/ байдаг. Үүнийг түүхэн үндэсгүй домог гэж хятад , монголын эрдэмтэд үздэг /13-ын 160-161/. Авьяас билигтэй, их арга ухаантан Маодунь дорнод хунарыг эзлэн дагуулж, Юэчжи нарыг довтолсоноор Монголын тал нутагт их хүчирхэг улс байгуулагдсан юм" гэж /13/ булзааруулахын аргагүй түүхэн үнэнийг нууц мэдээний зохиогч аргагүй зөвшөөрөн хүлээсэн боловч МЭӨ 136 онд Хүннү улс, Хятадын Хан улсын хооронд байгуулагдсан гэрээгээр хоёр улс бие биенээ мөр зэрэгцэх мөрш улс гэж зөвшөөрөн хүлээж, хоёр улсын хоорондын шилийг Хятадын Цагаан хэрмээр тогтоосон түүхэн үнэнийг /30-ийн 11, 18; 13-ын 94,95/ дурьдаагүй байна. Язгуур Монголын Их Нирун Улсыг /330 орчим-555/ ердөө л "Дараа нь Нирун /Жоужань/ нар говийн умарт хэсгийг эзлэн авлаа" гэж /14/ нэг талаар биеэ даасан улс мөн эсэх нь тодорхойгүй, нөгөө талаар харь угсаатан Монгол орныг эзэлсэн мэт болгожээ. Нирун нарын тухай хятад сурвалж бичгийн мэдээний түүвэр эмхтгэлийг /29-ийн 3-269/ үзэхэд Их Нирун Улс бол одоогийн Өвөрмонголын нутаг, Хятадын умарт хэсгийн зарим нутагт байсан табгачийн Вэй улстай /386-534/ мөр зэрэгцэн тэмцэлдсэн Төв Азийн нэгэн хүчирхэг улс байсан учир Хятад угсаатны Сун /420-479/, Өмнөд Ци /479-502/, Лян улстай /502-557/ найрсаг харилцаатай байсан юм /12-ын 10-63/. "Тан Улсын Чжэньгуань /627-649/ онд Тайцзун хаан Сэлэнгэ мөрний дээд урсгал, Онон, Хэрлэн голын хооронд, Хэнтийн уулын орчим газар, Онон голын дээд урсгал, Улаанбаатарын зүүн хойт /хэсэг/, Хангайн нурууны зүүн үзүүр зэрэг газарт зургаан муж /фу/, долоон гацаа /Чжоу/ байгуулсан" гэсэн /14/ нь түүхэн үнэнд огт нийцэхгүй зүйл байна. Одоогийн Монгол Улсын төв, баруун хэсэгт түр оршин тогтнож байсан Түрэг улс /555-745/ 630-680 онд Тан улсын түр эрхшээлд орсон боловч мөхөөгүй оршин тогтнож байв. Одоогийн Монгол Улсын нутгийн зүүн хэсэг, зэргэлдээ нутагт 30 татар гэх монгол улс байсныг Архангай аймгийн

нутаг Хөшөө цайдамд 732 онд түрэгийн түшмэл Кюль тегинд, 735 онд Билгэ хаанд босгосон хөшөөний түрэг бичээсэнд дурьдсан байдаг. "Тан /618-907/-аас хойш энд хитан /Ляо/ угсаатан, зүрчид /Алтан улс/ угсаатан дараалан гарахад тэр үеийн Хятадын умарт хил хязгаар нь баруунаас Горлос /Енисэй/ мөрний дээд урсгалаас Хар /Хэйлунцзян/ мөрний эхний урсгал хүрч, тэдгээрийн завсарт Байгаль далайн тойрны нутаг багтаж байв" гэж /14/ ихэд булзааруулан дурьдаад одоогийн Монгол улсын нутаг бүхэлдээ, мөн Байгаль далайн эргэн тойрны нутаг Хятад улсын харъяанд байсан юм шиг болгон хятад сурвалж бичгийн мэдээг эрээ цээргүй гуйвуулсан байна. Түүхэн үнэнийг хэлбэл Хитан /Ляо/ улс /907-1125/, мөн Алтан улс /1125-1235/ бол Хятад биш угсаатны биеэ даасан том улсууд байв. Энэ хоёр улсын үед Хятадын нутагт Сун улс /960-1279/ гэж том улс бас байсан юм. А.Виттфогель, Фэн Цзяшэн хоёр хитан улсын түүхийн нэлээд хэсгийг түүвэрлэн англиар орчуулан нийтлүүлсэн том бүтээлдээ хавсаргасан зураг дээр Хитан улсын хилийн баруун хойт хэсэгт барагцаалбал одоогийн Монгол улсын нутгийн 98-р уртрагаас зүүн тийш 45-р өргөрөгөөс урагш Хэрлэн, Тууя голын сав нутгийн өмнөд хэсэг 1004 оноос хамрагдаж байжээ /40-н газрын зургийг үзмүү/. Одоогийн Монгол улсын нилээд хэсэгт оршин тогтнож байсан Монгол улс Ляоши буюу Хитан улсын түүхэнд Монгол улс, Татар улс мэтээр тэмдэглэгджээ. Жишээлбэл, Татар улсын элчин Хитан улсад 918 онд ирж бэлэг барив. Монгол улсын элчин Хитан улсад 1084 оны 2-р сард ирж бэлэг барив гэж эрт тэгш улсын байдлаар Ляошид тэмдэглэжээ /31-н 1-р бүлэг 10 а тал, 24-р бүлэг 5 а тал/. Монгол улсын зүүн өмнөд өмнөд хил нь Алтан улсын үед одоогийн Монгол улсын хилтэй ойролцоо байсан юм.

Монголын нууц товчооны 142-р зүйлд Монгол улс Алтан улс хоёрын хоорондын хилийн хэрмийг утхива гэж нэрлэжээ. Хятадын нэрт эрдэмтэн Ван Говэй /1877-1957/ судалснаар Алтан улс 1147 оны 3-р сард Монгол улсын найрамдал хэлэлцээр байгуулан, хилийн зааг тогтоож Монгол улсад жил бүр үхэр хонь 250000 толгой өгч байснаа нэг дахин нэмж өгөхөөс гадна урьдынхаараа хил

ёр торго 300000 толгой, хөвөн бараа 300000 лангийн алба барихыг зөвшөөрчээ. Ингэхэд Монгол улсын хаан Уурборгил "Аолубоцзиле/ "Эхэн дээдэс" гэх өргөмжилсөн нэртэй, "Тэнгэрээс мандсан" гэх оны цолтой хаан болжээ /28-н 698/.

Нууц үгсэл номын зохиогчид "1206 онд Онон голын эрэгт Чингис хаан гэж нэрлэгдлээ" гэж /15/ Их Монгол Улс байгуулагдсныг дурьдсан болоод, Монголын цэрэг польш, унгарын цэргийг ихээр цохисон. Манлай цэрэг нь Венад тулж очиход Европ бүхэлдээ айн сүрдсэн. Монголын төмөр морьт цэргийн галзуурсан шуурга бүхэл Евразийн их нутгийг хураан авсан. Монгол хүмүүс хэдэн үеийн хүмүүсийн нүтгэлээр морины нуруун дээр яван эцсийн дүнд өргөн уудам их улсыг босгосон. Юан улс Хятад орныг нэгтгэн, Европ, Азийг донсолгосон юм" гээд Юан улсын захиргаанд хамаарагдах "Умарт хил хязгаар нутаг нь Онон, Хэрлэн голын сав, Горлос /Енисей/ мөрний сав, Ангар мөрний сав нутаг юм" гэж /16/ одоогийн Орос улсын Эрхүү хавь нутгийг Хятад улсын нутаг байсан мэт болгожээ. Юан улсын үеийн түүхийг тусгайлан судласан Чулууны Далай Юан улсын үеийн Монгол орны байдал, гадаад харилцаа цэргийг түүхэн баримтанд тулгуурлан үнэлсэн нь нууц үгсэл номын зохиогчдынхоос эрс өөр байна /8-ын 31-84/.

Нууц үгсэл номын зохиогчид 1368 онд Юан улс Хятадын тариачдын босолгонд дийлдэн мөхөссөнөөс хойш Монгол улс, Мин /1368-1644/ улсын харилцааны талаар дурдахдаа "Мин улс олон удаа цэрэг зэвсэг хэрэглэсэн. Гэвч монголын үлдсэн хэсэг ялагдсныхаа дараа бутаран салахад Мин улс хуваан захирах аргыг аргагүй эрхэнд хэрэглэн цэргээр байлдан дагуулахын оронд худалдаа арилжаа хийн татах зэргээр эер засах бодлогод шилжиж тэр үед Хятадын умарт хил хязгаарыг хянан захирах явдлыг яаж ийгээд /Мяньцян/ хангаж байжээ. Өрнө зүг Горлос /Енисэй/ мөрний дээд урсгалаас дорно зүг Хар /Хэйлунцзян/ мөрний дээд урсгалаас хойш одоогийн байгаль далайн хавь нутаг нь бүхэлдээ /сишу/ Хятадад эргэж ирлээ" гэж /6-17/ одоогийн оросын холбооны байгаль далайг оролцуулан Монгол улсын нутгийг санаан дураараа Хятадын харъяа нутаг болгон Хятад, Монгол сурвалж бичгийн мэдээг эрээ

цээргүй гуйвуулж байна. Ч.Далай Монгол улс, Мин улсын харилцааны талаар бичихдээ "Мин улс Монголчуудаас хамгаалах зорилгоор нийслэл хотоо Нанжингаас Бээжинд шилжүүлэн нүүлгэсэн билээ. Бас цагаан хэрмийн дагуу "есөн хязгаар" гэдэг есөн том бэхлэлт байгуулан үлэмжхэн тооны дарангуй цэрэг суулгажээ. Энэ бүхнээс үзэхэд тэр үед Монгол улсын байдал нэг их дорой бус, Мин улсыг айлгасан биеэ даасан хүч хэвээр байжээ. Энэ нь 44-н хоёрын төрийг нэгтгэсэн Эсэн хаан /1440-1450/ гарч Хятадын Ин Цзун хааныг олзолсон, Батмөнх хааны /1466-1504/ үед бүх Монгол нэгдэн хүчирхэгжиж байсан зэргээс тодорхой байна" гэжээ /20-ын 153/.

Нууц үгсэл номын зохиогчид Манжийн түрэмгийлэлийн эсрэг Монгол улсын тусгаар тогтнолын төлөө Галдан бошигтын тэмцлийг "Галдангийн урвалт самуун" гэж /18/ хэнэггүй нэрлэж байна. Галдан Манжийн цэрэгт ялагдсныг БНМАУ-ын түүхийн дэд ботид "Монголын тусгаар тогтнолын төлөө манжийн түрэмгийлэгчдын эсрэг Галдан бошигтын явуулсан олонжилийн уйггүй шургуу тэмцэлийнхүү төгсчээ" гэж /5-ын 112/ дүгнэжээ. "Галдан Монгол улсын тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч мөн" гэж Галданг /1644-1697/ тусгайлан судласан түүхийн ухааны дэд доктор С.Цолмон "Ардын эрх" сонинд /1994.2.18. №34/ нийтлүүлсэн өгүүлэлдээ бичиж байна. Шашны тэргүүн Жавзандамбын удирдлагаар халх монголчууд "эх орсны эхийн өвөрт эргэн орлоо!" гэж /18/ Нууц үгсэл номын зохиогчид бахархан дурьдаж байна. Халх монголчууд 1691 онд Манжид дагаар орсны гол шалтгааны тухан БНМАУ-ын түүхийн дэд ботид бичихдээ: "16-р зууны 2-р хагасаас хойш биеэ дааж орших болсон Халхын гурван ханы хоорондын холбоо 17-р зууны эцэст эрс суларч, хэн нэгнийхээ эрх захирамжыг нөгөөх нь хүлээн зөвшөөрөхгүй болж, өөрсөд зуураа шууд зэвсэг зөрүүлэн байлдаж байсан цагт бол үгсчүүлган дээр тэдний хэн нь ч бүх Халхыг төлөөлөн нийт Халхын улс төрийн хэргийг төлөөлж чадахгүй байжээ. Харин 17-р зууны тэргүүн хагаст шарын шашны тэргүүн гэгдэж өргөмжлөгдсөн Өндөр гэгээн Халхын ноёдыг бүхэлд нь төлөөлж чадах байсан юм. Гэтэл Өндөр гэгээн нь Манжийн Энх Амгалан хааны улс төрийн бодлогод автагдсан этгээс

Хэвцэс тул Манжид дагаар орохыг шууд зөвлөжээ. Сурвалж бичигт Өндөр гэгээнийг "Хойт зүгийн шар Хятад" /Орос-Дунгонгор/ хэмээх улсын хааны төр амгалан их боловч шашин эс дэлгэрсэн бөгөөд бас ч хувцасны зах буруу тул эд болмуй. Өмнө зүгийн хар хятад хэмээх улсын хааны төр шашин амгалан сайны дээр бас түүнд бурхны шашин дэлгэрсэн, ялангуяа Манжийн хааны эд агуурс нь тэнгэр тусын эд эрдэнэсийн хив хадаг, торго тэргүүтэн бүрдсэн их буянтай хаан мөний тул тэр зүгт явбаас төр тогтож, хамаг амьтан жаргамуй" гэж айлдсан гэжээ. Тийнхүү Жавзундамба хутагт Манжийн төр түшихийг ятган сургасаныг феодалын олонхи дагаж, тус /1688 оны/ чуулганаас Халхыг Манжийн захиргаанд орохыг зөвшөөрсөн шийдвэр гаргажээ" гэжээ /5-ын 92/. Жавзундамба Монголчуудыг "жаргамуй"-н замаар биш, харин туйлаас дарлагдан мөлжигдөж, мөхөх аюулын замд оруулан арван хар нүгэл үйлдсэнийг түүхийн бодит үнэн гэрчилж байна.

БНМАУ, БНХАУ-ын эрдэмтдийн судалснаар 20-р зууны эцэс гэхэд Монголын хүн амын өсөлт зогсон, хорогдож, монголчууд биологийн хувьд мөхөх аюулд орсон байв. Хүн ам зүйч, эмч Д.Гүр монголчууд мөхөж байна гэж европын эрдэмтэн Кооль-Эстивальд 1915 онд бичсний үнэн эсэхийг статистикийн талаар судлаад 1921 оны ардын хувьсгалаас өмнөх Монголд монгол хүн нас баралтаа нөхөх чадваргүй болж мөхөх аюулд орсныг харуулсан /6-ын 133-134/ юм. БНХАУ-ын эрдэмтдийн судалснаар "1570-1582 оны үед баруун, зүүн монголчууд 1090000 байжээ. Манж Цин улсын /1644-1912/ үед шарын шашин дэлгэрсэн нь монголын хүн амын өсөлтөнд нөлөөлөв. Манжийн Тэнгэрийн тэтгэсэн хааны /1736-1795/ үед монголын хүн ам хорогдон 1030000 болжээ. Түүнээс хойшхи зуу гаруй жилийн дотор хорогдон 1030000-аас 829000 болон хорогдсон" гэжээ /32-ын 51/. Энэ зуу гаруй жилийн дотор 201000 хүнээр буюу 19,5 хувиар хорогдожээ. Манжийн колончиллын үед монголын хүн ам 1090000 байснаа 261000 хүнээр буюу 23,9 хувиар хорогдон 829000 болсон байна. Манжийн колончилал Монголын ард түмэнд учруулсан нэг том хор хөнөөл бол хятадын худалдаач, мөнгө хүүлэгчдийн хатуу ширүүн мөлжлөгийн үр дүнд ард түмний аж амьдрал доройтсоор байсан явдал

мөн. "Монгол руу "нүүлгэх ажил эрхлэх тусгай товчоо" Бээжинд 1906 онд байгуулагдаж Халх монголын хүн ам, мал сүрэг, газар нутгийг бүртгэн данслах ажил хийж эхэлжээ... Бээжингээс засгийн газрын "нүүдлийн хэрэг эрхлэх товчоо" байгуулагдснаас хойш хоёр гуравхан жилийн дотор Халх Монголын шилдэг сайхан бэлчээрүүдийг булаан авч зааглаад тэндээс өдий төдий айл өрхийг мал сүрэгтэй нь хамт хөөн зайлуулж, хувхай хоосон газар руу шахан гаргах болсон билээ. 1911 онд энэхүү товчоо Халх Монголын 4905000 десятин /9 сая 319500 га/ газрыг хэмжээлэн зааглаж Бээжингийн мэдэлд шилжүүлэн авахаар шийдвэрлэжээ. "Нүүдлийн хэрэг эрхлэх товчооны" өөр нэг чухал үүрэг нь Монголыг нүүдлийн иргэдээр дүүргэх асуудал байжээ... Ер нь хятадын мөнгө хүүлэгчид монголчуудаас өндөр хүүтэй өрийн золиосонд мал сүргийг суурь сууриар авсаар өөрсдөө олон тооны мал бүхий аж ахуйтай болон хувирдаг үзэгдэл цөөнгүй байв... 1911 оны өмнө Ховдын хязгаарын олонхи Хошуунд ардуудын малын 80%, дорнодын хошуудад талаас дээш хувь нь хятадын олон пүүсний гарт орсон байв. Нийт Халх монголын өр 11000000 ланд /407 тонн/ хүрчээ. 1911 оны өмнө монгол нутгаар өлсгөлөн гуйлангачилал газар сайгүй тархадэлгэрчээ" гэж БНМАУ-ын түүхэнд дурьджээ /5-н 392, 396, 397/. Хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчидэд холбогдох Монгол улс архивын зарим хэрэглэгдхүүний эмхтгэлээр үзэхэд /1-н 4-75/ Монголын ард түмнийг хятадын худа лдаачид, мөнгө хүүлэгчид аймшигтайгаар шулам мөлжиж байжээ.

Манжийн колончлогчид монголчуудын төрөлх хэл болон монгол хэлийг ерөнхийдөө монголчуудын хоорондын харилцаа, нутгийн захиргааны албан хэрэг явуулах хүрээнд байлгахын зэрэгцээ монголын ард түмний ухамсараас түүхэнд дурсамж, түүхээрээ бахархах үзлийг арилгахын тулд үндэсний түүхийн ном, зохиолыг хураан авч үстган оронд нь "олон хуурамч ном судар" гаргадаг байв. Энэ талаар Ч.Далай бичихдээ: "Манж Цин улсын Найралт Төв /1727-1736/, Тэнгэрийн тэтгэсэн /1736-1796/ хааны үед монгол ном, зохиол шатаах нүгэлтэй ажил хийжээ. Энэ тухай "Дунхуа-лу"-д бичсэн нь: "Юнчжэн /Найралт төв

Цяньлун /Тэйгэрийн тэтгэсэн/ хааны үед олон хуурамч монгол судар хэвлэсэн. Бас монгол айлаар хадаглагдаж байсан ном судрыг цуглуулан хурааж аваад оронд нь бурхны судар тавьж олгосон" гэжээ. "Монгол, Төвдийн арван өдрийн сэтгүүл"-д бичсэн нь: "Манж, төвд хүмүүс монгол хэл мэддэггүй байснаас монгол хэлний ном судрыг үл итгэж, үе үе цуглуулан шатаагаад оронд нь бурхны судар тавьж олгодог байсан. Энэ тухай монгол, төвдийн зэрэг шийтгэх хурал дээр үргэлж маргаан үүсдэг байв" гэжээ. П.К.Козлов бичсэн нь: "Цайдам ба Хөх нуурын орчмын монголын эртний номсудар, тэмдэглэл баримтыг хятадууд удаа дараа устгаж байсан. Ийм ажил 200 шахам жил үргэлжлэн хамгийн сүүлийн удаа 1848 онд их хэмжээгээр шатаан сүйтгэсэн" гэжээ /8-н 11/. Манжийн хаан монгол ноёдод байсан угийн бичиг зэрэг монголын түүхийн зохиолын номыг хураан авч устгаад, оронд нь манжийн түрэмгийлэгчдийн бодлогыг зөвтгөн бичсэн "зарлигаар тогтоосон монгол хотон аймгуудын ван гүнгүүдийн илтгэл шастир" гэх 120 дэвтэр зохиолыг 1779-1795 онд тусгай дуулгавартай түүхчин түшмэдээр зохиолгон нийтлүүлжээ.

Монголын ард түмэн 2000 гаруй жилийн төрийн уламжлалтай биеэ даасан угсаатан байсан учир манжийн колоничлолыг эсэргүүцэн тэмцээр байгаад дотоод, гадаад гааламжтэй нөхцөл бүрдсэн 1911 онд тусгаар тогносон Монгол улсаа байгуулан үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлдээ ялалт хийсэнийг БНХАУ-ын төрийн байгууллагын жолоодлогоор бичигдсэн "Монгол үндэстний товч түүх" номд эрээ цээргүй гуйвуулан, монголын эх орончдыг доромжлон зүхэж бичихдээ: "Цагаагчин гахай жилийн /1911 оны/ хувьсгалын үеийн Монголын "тусгаар тогтнол", "өөртөө засах" хөдөлгөөн бол Ар Монголоос эхэлсэн бөгөөд Ар Монголын "тусгаар тогтнох" хөдөлгөөн нь бас хаант Оросын эзэрхэг түрэмгийтний урт хугацааны ухуулга ба шууд удирдан тоглосон байдал дор гарсан" гэж жүжиг мөн болгон дүрслээд цааш нь "Хаант Орос болон Жавзундамбын бүлэг бүх Ар Монголыг эзэмшихийн төлөө нэг талаараа эл газрын ван, гүн, дээд давхраатныг өдөөн урвалтанд оруулж, нөгөө

талаараа цэрэг томилон, Ар Монголын эл газрыг хүчирхийлэн эзлэв" гэжээ /10-н 588, 591/.

Нууц үгсэл номын зохиогчид нь Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд 1911 онд байгуулагдсан Монгол улсын үеийг хамарсан 4-р бүлгийг "цагаан Оросын дэглэсэн бузар жүжиг" гэж /115-179/ дээр дурдсан "Монгол үндэстний товч түүх" зохиолыг баримтлан нэрлэж Монголын эх орончдыг хараан зүхэж, түүхэн үнэнийг гуйвуулсан байна. Нууц үгсэл номд "Цагаан Оросын далд удирдлага, заавараар Жавзундамба тэргүүтэн улсаас урвасан ван, гүн, лам нар "тусгаар тогтнол"-д тун эрчимтэй бэлтгэн" тусгаар тогтносон улс болсон мэтээр өгүүлжээ /126-127/.

Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл бол нэг талаар монголын ард түмний үндэсний ба төрийн ухамсар, нөгөө талаар Манжийн колончилогчдын харгис хэрцгий дарлал, Хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдийн хайр найргүй мөлжлөгтэй салшгүй холбоотой болох нь уг тэмцлийн тухай архивын цөөвтөр баримт бичгийн эмхтгэлийн хэрэглэгдэхүүнээр бүрэн нотлогдож байна. Халхын дөрвөн аймгийн хан, ван, бээс, гүн, засаг жич Шанзудба, да лам нараас Монгол орон Манжаас тусгаарласан тухай 1911 оны 12-р сарын 1-нд зарласан ухуулах бичигт "Манай Монгол бол угтаа тусгай нэгэн улс мөн тул одоо хуучин журмаар өвсүвээн /өөрсдөө/ улс болон өөрийнхүү хэргийн эрхээ бусдаар эрхлүүлэхгүй, шинэ төр байгуулан тогтоохоор зөвлөн тогтсон" гэжээ /11-н 110/. Монгол улс Манжаас бүрэн тусгаарласнаа Хүрээн дэхь Оросын консулд мэдэгдсэн 1911 оны 12-р сарын 12-ны бичигт "Хятад болбаас манай Монголд хэзээний хамаадах явдалгүйн тул манай Монгол одоо хүрээний газар суусан манж, хятад сайд түшмэдийг нэгэнт хөөн зайлуулаад газар орон амар тайван болсон" гэжээ /11-н 169/. Монгол улс тусгаар тогтносноо Манжийн засгийн газарт мэдэгдсэн 1911 оны 12-р сарын 29-ний бичигт "Бээжингийн Гадаад хэргийн жургаан, Дотоод яам, Засагт тус хийх яамнаа толилохыг гуйн өргөхийн учир Монголчууд Чин улсад эдүүгэ хүртэл 200 илүү онд хязгаарын сайдууд ба жургааны түшмэд цаазыг

дэмүүруулан санааны дураар мөнгө зоос ховдоглон малжих нь бүх дэлхийд энэ мэт хаагдсан харанхуй газаргүй болон... Үндэснийг таслах, шашныг сөнөөх /Шинэ/ засгийн бодлого нь тэдний элэг уушигийг үзсэн мэт илэрчээ. Талхигдах, дарлахыг цааз болгон хувиргасан зүйл зүйлийг бийр цаасаар тоочин барахуйяа бэрх, түүний дээр гадаад зугаа найрамдалыг алдаж, хөдлөх бүр зах хязгаарт өө сэв өдүүлжээ. Монголчууд... бүгдээрээ Богдыг өргөмжлөн эзэн болгож, улсын цолыг Монгол хэмээн үе уламжлан умар зүгийн орон газрыг уул эзэн нь хураан авч бүрэн болгон батлав" гэжээ /11-н 169-170/. Оросын Цагаан хаанаас тусламж эрж 1911 оны 6-р сарын 29-нд өргөсөн 21 зүйлд дурьдахдаа: "Нэгэн зүйл, Монгол газар Шинэ засаг дэлгэрүүлэх нэрээр шалтгаалж олон иргэнийг /хятадыг/ нэн үлэмж хуруулан, Халхын хойт хязгаарын хэд хэдэн хошууны нутгийг зөнд нь хаглан тариа тариулж, нутаглан суулгахаар нэгэнт тогтоон бүхүй нь Монголын амьдралыг нэгмөсөн тасалж, хойд хязгаар захыг баталъяа хэмээсэн санаа лавтайяа мөн тул нэн цухалдаж хорсох билээ...

Нэгэн зүйл, Угаас тогтсон хуульд монгол, иргэн /хятад/ харилцан ураг барилдах ёсгүй бөгөөд одоо Шинэ засгаар шалтгаалж, хуучин хуулийг халж монгол, иргэн харилцан ураг барилцахаар ноднин жил зарласан нь гнэхээрийн хортой санаа мөн бөгөөд энэ мэт харанхуй засгийг манай Монгол яахин дагаж чадах билээ" гэжээ /11-н 165-166/. Монголчууд өөрсдөө өөрдийгөө мөхөх аюулаас аврахаар уламжлалт төр ёсоо сэргээсэн түүхэн бодит үнэн архивын хэрэглэгдэхүүнд туссан нь ийм байна.

БНХАУ-ын эрдэм шинжилгээний албан ёсны хэвлэл болох "Монгол үндэстний товч түүх" номд Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө 1911 оны тэмцлийг түүх гуйвуулан "хүчингүй болгосон", мөн БНХАУ-ын Төрийн зөвлөлийн хэвлэлийн газрын 1992 оны 9-р сарын албан ёсны баримт бичигт одоогийн Монгол улсыг "Хятадын умарт хязгаар" гэж үзсэн //24-н 2/ учир 1921 оны Монгол ардын хувьсгалын ялалтын үр дүнд байгуулагдсан БНМАУ бол БНХАУ-ын албан ёсны зохиомол үзлээр орших тогтнох "түүхэн үндэсгүй" мэт болж байна. Ийм учир Нууц үгсэл номын зохиогчид БНХАУ-ын албан ёсны энэ зохиомол үзлийг

баримтлан, Монгол ардын хувьсгалын нөлөө, Зөвлөлт улс Монголын хувьсгалчидад тусалсан зэрэг үйл явдлыг хамарсан тавдугаар бүлгээ "Эзэнт улсын зүүдээ дахин зүүдэлсэн нь" гэж /180-239/ нэрлэн залуу Зөвлөлт улсыг мөн л хаант Оростой адилтган гүтгэж хятадын харгис хүчний явуулгыг зөвтгөж, монгол ардын хувьсгалыг үгүйсгэсэн байна. Баруун европод 200 жилийн өмнө нэгэнт үеэ өнгөрүүлсэн феодалын байгуулалыг эх орондоо халах, хятадын цэргийн харгис дарангуйлалыг устгах, хятадын шунахай худалдаачид, мөнгө хүүлэгчдийн ноёрхолоос ангижран малчин ардын ангид засгийн эрхийг эдлүүлэх нь 1921 оны монгол ардын хувьсгалын гол зорилго байсан юм. Энэ зорилгыг биелүүлэхэд зөвлөлтийн улаан цэрэг монголын ард түмэнд зохих ёсоор тусалсан юм. Энэ бүлгийн 1-р зүйлийн "хувьсгалт нам үүссэн нь" гэх 2-р дэд зүйлд "Гадаад Монголын хувьсгалт намын уриа, үзэл бодол бол хятад үндэстний бүрэн эрх ашигт илэрхий харшилж, улсын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд хор хохирол учруулж байна. Гадаад Монгол бол эрт үеэс Хятад улсын нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг мөн" гэж /184/ их хан үндэстний дээрэнгүй үзлээ илэн далангүй илээр илэрхийлж байна.

БНМАУ-ын 1924-1945 он хүртэлх үеийг хамарсан 6-р бүлгийг "Хавцал дундах тусгаар тогтнол" гэж /240-341/ нэрлэжээ.

"1924 оны 5-р сарын 31-ний "Хятад, Зөвлөлтийн хэлэлцээ" -д гарын үсэг зурсан явдал бол Хятад улсад империалист тулган хүүлээлгэсэн эрх тэгш биш гэрээнүүдийг цөмөлсөн асар том цохилт мөн. Гэвч "Хятад-Зөвлөлтийн хэлэлцээ" Гадаад Монголын тухай асуудлыг бүрэн шийдвэрлэх чадаагүй. 1924 оны хэлэлцээгээр Гадаад Монголыг Хятад улсын нэг хэсэг мөн гэж зөвшөөрөн хүлээсэн боловч Гадаад Монголыг тусгаар тогтносон улс мөн гэж зөвшөөрөн хүлээсэн, Монголд зөвлөлтийн цэргийг байрлуулахыг зөвшөөрсөн "Зөвлөлт-монголын хэлэлцээ" -ийг хүчингүй болгоогүй юм" гэсэн /274/ нь ерөнхийдөө үнэн байдалд нийцэж байна. "Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс /ЗСБНХУ/, Бүгд Найрамдах Хятад Улс /БНХУ/-ын хоорондын асуудлуудыг зохицуулах

эрхний зарчмуудын тухай хэлэлцээ"-нд ЗСБНХУ-ын төлөөлөгч Л.М.Харахан, БНХУ-ын Гадаад Явдалын яамны сайд Ви Куин Веллингтон Ку нар 1925 оны 5-р сарын 31-нд сарын үсэг зуржээ. "Тавдугаар зүйл. ЗСБНХУ-ын Засгийн газар нь Гадаад Монголыг БНХУ-ын бүрэлдэхүүн хэсэг мөнгөж зөвшөөрөн хүлээж, тэнд БНХУ-ын бүрэн эрхийг мэдэгтгэж байна. Гадаад Монголоос ЗСБНХУ-ын бүх цэргийг татах тухай, тухайлбал эдгээр цэргийг татах цаад талын хугацааны тухай, мөн хилийн аюулгүй байдлын ашиг сонирхолын талаар авах арга хэмжээний тухай асуудлуудыг энэ хэлэлцээний хоёрдугаар зүйлд заасан бага хурлаар тохиролцмогц Гадаад Монголоос ЗСБНХУ-ын бүх цэргийг бүрэн татна гэдгийг ЗСБНХУ-ын Засгийн газар зөвшөөрөн хүлээж байна" гэж 15 зүйлтэй уг хэлэлцээнд заажээ /26-н 85/. БНМАУ-ын талаар дурьдсан зүйл нь ердөө энэ байна. ЗСБНХУ Монгол улстай байгуулсан гэрээ, хэлэлцээг энд огт дурьдаагүй байна, ЗСБНХУ энэ хэлэлцээнээс хойш БНМАУ-тай тусгаар тогтносон улсын ёсоор харилцаар байгаад 1945 онд Ялтын Бага хурлаар БНМАУ-ыг Америк, Англи, дараа нь Хятад улсаар зөвшөөрүүлэн уг хэлэлцээг хүчингүй болгуулсан юм. Иймд энэ хэлэлцээ бол үнэн хэрэг дээрээ БНМАУ-ын эрх ашгийг огт хөндөөгүй байна. Иймд энэ бол түр зуурын тактикийн асуудал байжээ. Энэ талаар Японы эрдэмтэн Ф.Исоногийн судалгаа түүхэн үнэнд нийцэж байна гэж үзнэ. Тэр хэлэхдээ: "1921 оны 3-р сарын 1-ний "Норт Чайна Херальд" сонинд бичсэнээр Москвад болсон намын их хурлын дараа Троцкий: "Японтой хийж болзошгүй дайныг хойшлуулахын тулд ямарч үнээр хамаагүй Хятадаар манай засаг төрийг хүлээн зөвшөөрүүлж, арилжаа худалдаа нээж, нэн дотно найрамдал харилцааг байгуулахаар шургуу чармайх нь манай засгийн газрын бодлого мөн" гэж хэлжээ... Зөвлөлтийн удирдлагыг хүнд мухардалд оруулсан нь Монгол Ардын нам Хятадтай байлдахын тулд зэр зэвсэг хүсэж байсан явдал бөгөөд гэтэл Хятад нь Гадаад Монголын статусыг өөрийн бүрэн эрхэнд хамаарах асуудал гэж үзэж ирсэн нь түүхийн хувьд тодорхой билээ. Нөгөө талаас хэрвээ Монголын ардын намын хүсэлтийг эс хүлээн авбаас монголчуудын найдлагыг хөсөрдүүлээд зогсохгүй

Зөвлөлтийн өндөр дуугаар зарлаж байсан дарлагдсан ард түмнийг чөлөөлөх тухай урианд итгэх итгэлийг алдагдуулах байв... Гэвч Зөвлөлтийн Засгийн газар Монголын болон Хятадын дэвшилт бүлгийнхнийг эвлэрүүлэх төдийг хүсэж байсан бишээ. Хамгийн чухал зорилт аваас Хятадын засгийн газартай албан ёсны дипломат харилцаа тогтоох явдал байв" гээд Сун Ятсен, мөн хувьсгалчид ч Монгол улсын тусгаар тогтнолыг огт зөвшөөрөн хүлээдэггүй байсныг цохон дурьджээ /15-н 40-41, 43/. Зөвлөлт улс Хятадтай хэлэлцээ хийн хэвийн харилцааг тогтоох түр зуурын тактик хэрэглэн Монгол улсыг хятадын хэсэг мөн гэж түр зуур зөвшөөрөн хүлээсэн байна.

Гурван их гүрний ялтын бага хурлаар И.В.Сталиний болзолгоор Америк, Англи хоёр БНМАУ-ын статус кво-г /тусгаар тогтносон улсын бодит байдлыг/ хүлээн зөвшөөрч, улмаар Бүгд Найрамдах Хятад Улс нь БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон үйл явдлыг голлон өгүүлсэн 7-р бүлгээ "улс төрийн хүчтэй шахалт дахь Эмгэнэлт явдал" гэж /342-388/ нууц үгсэл номын зохиогчид нэрлэжээ. Крымийн Ялтын Ливадийн ордонд 1945 оны 2-р сарын 4-11-нд болсон бага хурлаас Алс дорнодын асуудлын талаар байгуулсан хэлэлцээрт: "Дор тоочсон болзлыг хангах юм бол Герман улс буун өгч, Европт дайн төгссөний дараа хоёр-гурван сар болоод Зөвлөлт Холбоот Улс холбоотнуудын талд Японы эсрэг дайнд оролцоно гэж Гурван Их Гүрэн-Зөвлөлт Холбоот Улс, Америкийн Нэгдсэн Улс, Их Британий удирдагчид зөвшөөрөлцсөн, Үүнд:

1. Гадаад Монголын /Бүгд Найрамдах Монгол Ард Улсын/ статус-квог хэвээр байлгах.

2. Японоос 1904 онд итгэлийг эвдэж халдан довтолсноор зөрчигдсэн Орос орны эрхүүдийг сэргээх...

3. Курилийн арлуудыг Зөвлөлт Холбоот Улсад шилжүүлэх.

Гадаад Монголын тухай болон дурьдсан боомт, төмөр замын тухай хэлэлцэн тохиролцсон зүйлийг генералиссимус Чан Кайши зөвшөөрсөн байх шаардлагатай гэж үзэв. Маршал И.В.Сталины зөвлөснөөр тийм зөвшөөрөл авах арга хэмжээг ерөнхийлөгч авна. Японыг ялсны дараа Зөвлөлт Холбоот Улсын эдгээр шаардлагыг яриангүй хангах ёстой гэж Гурван

их Гүрний Засгийн газрын Тэргүүн нар зөвшөөрөлцөв" гэжээ /14-н 216-217/. Энэ хэлэлцээрт 1945 оны 2-р сарын 11-нд ЗХУ-ын И.В.Сталин, АНУ-ын ерөнхийлөгч Франклин Рузвельт, их Британий ерөнхий сайд Уинстон Черчилль нар гарын үсэг зуржээ. Хятадын засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрөн хүлээснээ 1946 оны 1-р сарын 5-нд албан ёсоор мэдэгдсэн гэж Нууц үгсэл номд дурьджээ /383/. Ингээд Зөвлөлт Холбоот Улсын дараа БНМАУ-ын тусгаар тогтнолыг Хятад улс зөвшөөрөн хүлээж дипломат харилцаа тогтоосон хоёрдахь улс болсон нь И.В. Сталины шургуу тэмцлийн үр дүн мөн нь тодорхой байна.

БНМАУ-ын тусгаар тогтнолыг цуцлан БНХАУ-д нийлүүлэх тухай асуудлыг Зөвлөлтийн шинэ удирдлагад 1954 онд тавьсан тухай дэлгэрэнгүй дурьдсан 8-р бүлгээ "Мао Цзэдунгийн эцсийн хүчин чармайлт" гэж /389-416/ Нууц үгсэл номын зохиогчид нийгмийн сэтгэл судлалын хувьд маш онож нэрлэжээ. БНМАУ-ын тусгаар тогтнолыг устган БНХАУ-д нийлүүлэх гэж Мао дарга тань 1949 оноос эхлэн оролдсоор байгаад 1954 онд эцсийн хүчин чармайлтаа гарган тэмцээд чадаагүй юм шүү, одоо Хятадын ажил хэрэгч хүмүүс, үйлдвэр, худалдааны хүмүүс та нар хүчин чармайлх хэрэгтэй гэсэн мэт нэр өгсөн байна. БНХАУ-ын удирдагч Мао Цзэдун БНМАУ-ын тусгаар тогтнолыг устган Хятадад нийлүүлэх бодлогыг угаасаа баримтлан байжээ. Мао Цзэдун Эдгар Сноутай 1936 оны 7-р сарын 23-нд ярилцахдаа Хятадад хувьсгал ялсны дараа БНМАУ нь Хятадын нэг хэсэг болно гэж хэлжээ /35-н 110, 444/. Нууц үгсэл номд бичсэнээр 1945 оны 8-р сард Хятад улс Зөвлөлт Холбоот Улстай гэрээ байгуулан БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрөн хүлээснийг Мао Цзэдун 8-р сарын 14-нд сонсон "нурууных нь хүйтэн хөлс асгарч" байжээ /398/. Мао цзэдун тэр үед Яньаньд Хятадын дотоод, гадаад байдлын талаар тавьсан илтгэлд Монголын асуудлыг хөндөж байжээ /398/. Нууц үгсэл номын зохиогчид 1949 оны 12-р сард Мао Цзэдун Москвад анх удаа очоод Сталинтай уулзан ярилцаад байсантай холбогдуулан БНМАУ-ын тусгаар тогтнолын талаар дурьдаад /405, 409, 411/ эцэст нь БНМАУ-ыг БНХАУ-д нийлүүлэх тухай асуудлыг Зөвлөлтийн удирдлагад 1954 онд хэрхэн тавьсан

тухай тодорхой өгүүлжээ /415-416/. БНМАУ БНХАУ-тай хилээ тодорхой тогтоох асуудлыг тавьсныг дурьдаад: "Энэ бол үнэхээрийн нэг нарийн асуудал юм. Монгол бол нэг нь "тусгаар тогтносон" гэгч БНМАУ, нөгөө нь Хятад улсын хил доторх нэг хэсэг, тухайлбал Өвөр монгол гэж хоёр хуваах арга бараг байхгүй юм. Монгол ийнхүү хоёр хуваагдсаныг ямраар ч ярилаа гэсэн энэ нь монголын ард түмэн нэгэн бүхэл байх ашиг сонирхолд хор хүргэхээс зайлсхийх аргагүй юм" гэж /416/ нууц үгсэл номын зохиогчид маш онцлон дурьдсан нь Мао Цзэдун 1936 онд Эдгар Сноутай ярилцахдаа БНМАУ-ын талаар хэлсэн санааг сэргээн Монгол улсыг БНХАУ-д нийлүүлэх ажлыг орчин үеийн нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд шинэ нармай монголын үзэл /неопанмонголизм/-ийг ашиглах гэж байгааг харуулж байна. Христофор Атвуд, Линколн Кае /АНУ/ нар Гонконгт гардаг сэтгүүлд 1992 онд нийтлүүлсэн өгүүлэлдээ сүүлийн жилд Монгол Улс Өвөр Монголын хооронд харилцаа сэргэсэнтэй холбогдуулан дурьдахдаа: "Хятадын худалдааны фирмийн орон нутгийн ажилтан монгол эмэгтэй анхны гадаад монгол эрэгтэй хүнтэй уулзаад, "Бид энэ амьтадтай нэгдэх гэж юунд хүсч байдаг билээ дээ?" гэж гайхан өгүүлнэ. Гэвч Хөх хот дахь монгол сэхээтнүүд нь нэгдэхгүй юм гэхэд, коммунизмын дараах Ертөнц дэх Өвөрмонголын байр суурь ямар байх бол? гэж бодох болжээ. Одоо Улаанбаатарт суудаг Өвөр Монголын ид идэвхтэн Мөрөн мэтийн зарим нь өөртөө засах орныг Хятадын чөлөөт холбооны бүрэлдэхүүн улс болгох асуудал тавьдаг. Энэ үзлийг Сун Ятсен 1924 онд, Мао Цзэдун 1945 онд дэмжихээ илэрхийлж байсан удаатай" гэжээ /36-н 19/. Халх монголчууд, Өвөрмонголчууд нь Манжийн захиргаанд 200 гаруй жил тус тус байгаад, сүүлийн 80 шахам жил биеэ даасан тусгаар тогтносон хоёр улсын дотор аж төрсөөр байсны улмаас хоёр өөр монгол үндэстэн болсон нь амьдралын бодит байдал мөн. БНХАУ-ын 1990 оны хүн амын 4 дэх тооллогоор Өвөр Монголын Өөртөө Засах орны хүн ам 21 сая 456800 байсны 80,6 хувь буюу 17 сая 298700 нь хятад, 15,7 хувь буюу 3 сая 375200 нь монгол хүн байна /32-н 47, 51/. Өвөр монголын нилээд хэсэг нь монгол хэлээ мэддэггүй юм. Хоёр монгол нийллээ

гэж бодоход Өвөрмонголын нийт хүн амын дөнгөж 26,9 хувь болж байна, ингэхлээр БНХАУ-ын жижиг автономит муж л болж болно.

Монголчууд зөвхөн хүчинд автагдан 1915 онд хоёр хуваагдсан үнэн түүхтэй. Орос улс, Хятад улс хоёр 1915 оны 5-р сард Монгол улсыг хүч түрэн албадан Хятадын харьяаны Автономит улс, Өвөр Монголыг Хятадын муж болгон хоёр хуваасан /9-н.2-52/. Ингээд Халх монголын монголчууд 1921 онд цусаараа тусгаар тогтнолоо байлдан олсон юм. "Монгол, Хятадын хил зааглагдан тогтсон юм" гэж /416/ зохиогчид бичнэ. Манай Монгол улсын 2200 гаруй жилийн төр ёсны уламжлалын нэг чухал хэсэг нь тусгаар тогтносон улсынхаа хилийг хамгаалах явдал байсаар ирсэн, одоо ч байсаар байна. Монгол улсын УЛСЫН Аюулгүй байдлыг хангах ерөнхий газар Монгол улсын хил хамгаалалтын түүхийг Хүннү улсын үеэс эхлэн харуулсан хэдэн газрын зурагтай /9-н 433-438/ том бүтээлийг 1993 онд нийтлүүлсэн нь үүний тодорхой гэрч мөн. БНМАУ, БНХАУ-ын хоорондын хилийн шугам тогтоон, хоёр улсын хилийн гэрээг 1962 оны 12-р сарын 28-нд байгуулж, гарын үсэг зуржээ.

1950 оны 2-р сарын 14-ний өдөр "Хятад, Зөвлөлтийн найрамдал, холбоотон, харилцан туслах тухай гэрээнд" албан ёсоор гарын үсэг зурсан юм" гэсэн /410/ өгүүлбэрийн талаар нэмж хэлэх зүйл бол уг гэрээ байгуулсан тухай хоёр улсын хамтарсан мэдэгдэлд "1945 онд явуулсан санал хураалтын ба БНМАУ-тай БНХАУ дипломат харилцаа тогтоосны үр дүнд БНМАУ-ын тусгаар тогтносон байдал бүрэн хангагдсан гэж хоёр засгийн газар батлан тогтоож байна" гэж /"Известия" сонин, 1950.2.15.№39/ ЗСБНХУ, БНХАУ албан ёсоор БНМАУ-ын тусгаар тогтнолыг дахин бататган дэлхий дахинд албан ёсоор мэдэгдсэн явдал юм.

1924 онд Бүгд Найрамдах засаг тогтоосноос хойших БНМАУ-ын түүхэн хөгжлийн үеийг хамарсан 9-р бүлгээ "Зөвлөлтийн 16 дахь нэмэгдэл бүгд найрамдах улс" гэж /417-459/ Нууц үгсэл номын зохиогчид бусдын үгээр нэрлэсэн нь хан үндэстний дээрэнгүй үзлийн үүднээс монголын ард түмнийг дээрэлхэн доромжилсон хэрэг гэж үзэхээс өөр арга байхгүй. Монголын ард түмэн өөрийнхөө олон мянган жилийн түүхээрээ бүтээсэн эрх чөлөө, тусгаар тогтнолоо

сэргээн босгох нь түүний бүрэн эрх, бүр эдүүгээчилбэл хүний эрх мөн нь мэдээж. Түүх бол амьд хүмүүсийн үйл ажиллагааны систем нийлбэр мөн гэдэг нь эрүүл ухаантай хүн бүр мэдэх хамгийн энгийн үнэн мөн. Түүхэн явдал, түүхт хүмүүс, тэдгээрийн үйл ажиллагааг мөн амьд хүмүүс үнэлнэ. Аливаа амьд хүмүүс бол тухайн нийгмийн "бүтээгдэхүүн" мөн байдаг учир сэтгэл судлалын /психологийн/ хүртэхүйн хамааралтай байдаг нь сэтгэл судлалын наад захын үнэн мөн. Ийм учир 1921 оны Монголын ардын хувьсгалын ялалтын үр дүнд байгуулагдсан БНМАУ-ын түүхэн хөгжлийг уг хувьсгалаар унагагдсан монголын хар, шар феодал, тэдний удам, хятадын мөнгө хүүлэгчид, худалдаачдын төлөөлөгчид, хан үндэстний дээрэнгүй үзэлтэн нар өөрсдийнхөө хүртэхүйн хамаарлаар үнэн голоосоо нааштай үнэлэхгүй нь сэтгэл судлалыг төсөөлөх орчин үеийн хүн бүрт тодорхой байна. Иймд БНМАУ-ын 70 жилийн түүхэн хөгжил бол:

а/. Дэлхий дахины бодит байдал;

б/. Хөрш хятад улсаас БНМАУ-ын талаар баримталсан бодлого, түүнээ хэрэгжүүлэхийн төлөө явуулсан ил далд ажил явууллага;

в/. Зөвлөлт Холбоот Улсаас БНМАУ-ын талаар баримталсан бодлого, түүнээ хэрэгжүүлэх талаар явуулсан ажиллагаа;

г/. БНМАУ-ын зүүн хилд байрлаж байсан Японы армиас БНМАУ-ын талаар явуулсан ил далд ажил явууллага;

д/. Хятад, Зөвлөлтийн хоорондын бодит харилцаа;

е/. БНМАУ-ын дотоодод болсон үйл явдлууд;

ё/. Бусад улсаас БНМАУ-ын талаар баримталсан бодлого, түүнээ хэрэгжүүлэхийн төлөө явуулсан ажиллагаа гэдэг долоон хүчин зүйл хэрэгжиж шууд, шууд бусаар оролцсон монгол, орос, хятад, япон гэх мэтийн амьд хүмүүсийн бодит үйл ажиллагааны систем нийлбэр үр дүн мөн нь эрүүл ухаантай ерийн хүмүүст тодорхой байна. Энэ 70 жилийн бодит үнэн байдлыг хялбарчлан бүдүүвчилж, БНМАУ ганцхэн Зөвлөлт Холбоот Улсын "эрхшээлд 70 жил байсан" мэт БНМАУ-д 1930-1940-өөд онд болсон улс төрийн хэлмэгдүүлэлт бол "Сталины заавраар" ганц "Чойбалсан хийсэн ажил" мэт болгон тавих нь түүхэн үнэн байдлыг

дээд зэргээр гуйвуулсан хэрэг мөн нь эрүүл ухаантай ерийн хүмүүст тодорхой. 1939 онд болсон Халхын голын дайн БНМАУ-ын хөгжилд тус болоогүй гэдэг нь маргаангүй, ингэхлээр БНМАУ-ын хөгжилд Япон тус болоогүй, саад болж байсан нь тодорхой. Дорнод европын социалист орнууд наанаа хэлэхэд 1960-аад оноос эхлэн БНМАУ-тай эдийн засгийн талаар хамтран ажиллаж байсан, Нэгдсэн үндэстний байгууллага 1961 онд БНМАУ-ыг тусгаар тогтносон улс гэж албан ёсоор зөвшөөрөн хүлээж гишүүнээ болгосон, дэлхийн 100 гаруй улс БНМАУ-тай дипломат харилцаа тогтоосон билээ. Энэ бүхнийг зөвшөөрөн хүлээхгүй байгаа энэ номын зохиогчдыг их хан үндэстний дээрэнгүй үзэлтнүүд гэхээс өөрөөр нэрлэх арга байж болно гэж үү?

Нууц үгсэл номын зохиогчид 9-р бүлгийн 1-р зүйлийг "Орчин үеийн нүдний өмнөх Монгол улс" гэж /417-420/, 1-р дэд зүйлийг "Хэцүүхэн "тусгаар тогтнол" гэж /417/, 2-р зүйлийг "Зөвлөлтийн том бэлчээр нутаг" гэж /420-431/. Зөвлөлт Холбоот Улсаас БНМАУ-д үзүүлсэн тусламж, БНМАУ-ын тусгаар тогтнолыг бүрэн үгүйсгэн нэрлэжээ. 1921-1991 оны хооронд БНМАУ-д Зөвлөлт Холбоот Улсаас илүү нааштай хандах, илүү сайн туслах өөр ямар нэг улс энэ дэлхий дээр байсан уу? гэх асуулт аяндаа гарна. Байгаагүй гэх хариултыг хэн ч няцааж чадахгүй. Зөвлөлт Холбоот Улс нь империализмын колонийн системийг устгахад гол үүрэг гүйцэтгэсэн, хүн төрөлхтнийг фашизмын аюулаас аврахад гол үүрэг гүйцэтгэснийг үгүйсгэх аргагүй. Зөвлөлтийн цэрэг БНМАУ-ын цэргийг оролцуулан Хятадын зүүн хойт хэсгийг Японы цэргээс чөлөөлснийг нууц үгсэл номын зохиогчид дурьдсан байна /365-376/. Ийм улс, тухайлбал Зөвлөлт Холбоот Улс БНМАУ-ыг "том бэлчээр нутаг" болгосон /420-439/ гэдэг үнэн үү?

Энэ талаар бодит байдлыг алагчлахгүй үнэлсэн хүмүүсийн судалгааг авч үзье.

Японы эрдэмтэн Ф.Исоно 1920-1991 онд Зөвлөлт-Монголын харилцаатай холбогдуулан хэлэхдээ: «Өгүүлэн бүхий хугацаанд Зөвлөлтийн удирдагчид чухам хэрхэн зөвлөлдөж байсныг тогтоох нь бэрхшээлтэй боловч тухайн Үеийн Оросын бодит байдлыг үзвээс тэд тэр цагт нөлөөгөө

өргөтгөн тэлэх түрэмгийллийн замыг сонгож авсан гэж төсөөлөх аргагүй. 1950-аад он болоод байхад ч Өрнөдийн нэгэн судлаачийн бичсэнээр "Зөвлөлтөөс Монголд цутгаж байгаа хөрөнгөтэй харьцуулах юм бол Монгол нь Зөвлөлтийн эдийн засагт материал нэмэр болж байгаа зүйл бараг үгүй" гэдгээс үзсэн ч Зөвлөлт эдийн засгийн сонирхлын үүднээс ашигт малтмалаар баялаг ч тээврийн хэрэгсэл хөгжөөгүй Монголд цэргийн ажиллагаа явуулах учиргүй" гэжээ /15-ын 40/. "Эрдэнэт" зэрэг монгол-зөвлөлтийн хамтарсан үйлдвэрүүдийг "Монголын нөөц баялгийг Зөвлөлт улс дээрэмдэх амархан хаалгыг ихээр нээсэн юм" гэж /428/ нууц үгсэл номын зохиогчид дүгнэж байна. Энэ бол үндэсгүй гүтгэлэг мөн болох нь Монгол Улсын төр, засгийн төв хэвлэлүүдэд 1993-1994 онд Аж Үйлдвэрийн комбинатын 60 жил /Ардын эрх, 1994.3.25. №058/, Монголросцветмет нэгдлийн 20 жил /Засгийн газрын мэдээ, 1993.10.19-22, №67/, "Эрдэнэт" уулын баяжуулах үйлдвэрийн 20 жилийн тухай /Ардын эрх, 1993.12.16, №208. мөн 1994.2.18, №14/ нийтлэгдсэн албан ёсны мэдээ, сурвалжлага зэргээс тодорхой байна. "АНУ-ын "Артур", "магна", Чилийн "Чукимата", Канадын "Бренда", Перугийн "Токональ" зэрэг дэлхийн зартай аварга үйлдвэрүүдтэй эн зэрэгцэх "Эрдэнэт" үйлдвэрийг ердөө л дөрөвхөн жилд монгол-зөвлөлтийн хамтын хүчээр босгосон нь Монголын түүхэнд урьд хожим байгаагүй аварга амжилт байлаа.

Монгол-Зөвлөлтийн хоорондын харилцаанд алдаа дутагдал, зарим сөрөг тал байсан боловч БНМАУ Зөвлөлтийн 16 дахь нэмэгдэл Бүгд найрамдах улс "Колони" байсан гэж батлах бодитой баримт нотолгоо байхгүй байна. БНМАУ Зөвлөлт Холбоот улсын тусламжийн ачаар 1984 оны дундуур дэлхийн дундаж орлоготой эдийн засаг бүхий Мексик, Египет зэрэг 41 орны тоонд орж байсныг дэлхийн эдийн засгийн том бүтээлд тэмдэглэжээ /38-н 800/. "Ардын эрх" сонины 1994.07.09-ний 134-135-рт нийтлэгдсэн мэдээгээр Монгол Улс 1993 онд дэлхийн 173 орон дотор 100 дугаар байрыг эзлэн, өмнөх Үеийнхээсээ 10 гаруй байраар ухарсан боловч дэлхийн дунд зэргийн хөгжилтэй орнуудын тоонд орсон хэвээр байна. Гэтэл БНХАУ, Энэтхэг нь дэлхийн бага орлоготой 34 орны тоонд

орж байжээ. БНМАУ 1921-1991 он хүртэлх хугацаанд феодал-колонийн хамгийн хоцрогдсон Монгол орноос орчин үеийн улс болсон нь албан ёсны хамгийн сүүлчийн статистикийн баримт бичгээс тодорхой харагдаж байна /4-н 3-143/.

Нууц үгсэл номын зохиогчид Монгол улсын дотоод хэрэгт эрээ цээргүй дээрэнгүй оролцож БНМАУ-д болсон улс төр, соёлын зарим үйл явдал, арга хэмжээг өөрсдийн үзлийн үүднээс санаан дураар авч үзсэн байна. "Соёлын талаар 1940 оны үед Монгол нь орос үсгийг хэрэглэн, монгол бичгийг халсан нь дэлхийн түүхэнд тохиолдсон маш гайхалтай зүйл юм. Зөвлөлт улс давын өмнө монгол хүмүүст бага сургуулиас орос хэл үзэхийг албадан тулгасан...Зөвлөлт улс үнэндээ хэлээр далимдуулан, монгол үндэстний урт үеийн эх булагтай гандашгүй соёлын уламжлалыг устгаж, бүх хүчээ шавхан орос хэл хэрэглэж монгол хэл, монгол бичгийг шахан зайлуулахыг чармайж, монголчуудаар өнгөрснийг нь таягдан хаяулж, монгол орос үндэстний хооронд түүхэнд бүрэлдсэн хөндий байдлыг арилгахыг оролдож, монгол үндэстний эсэргүүцэх эр зоригийг сарниулан мөхөөж, тэднийг өнөөдөрт; бодит юманд зүтгүүлж, монгол үндэстний түүхэн дэх яруу алдарт сайхан мөчийг мартуулж байв" гэж /433-434/ Нууц үгсэл номын зохиогчид ямарч баримт, нотолгоогүй юмыг үнэн болгон өгүүлсэн байна. Монголын сэхээтнүүд орчин үеийн шинжлэх ухаан, техникийн мэдлэг, мэргэжил эзэмших боломжтой болох хамгийн хямд найдвартай хэрэгсэл бол орос хэл сурах явдал байсан, одоо ч хэвээр байгаа нь мэдээжийн тодорхой зүйл юм. Зөвлөлт, Оросын эрдэмтдийн бүтээлд монгол угсаатан, үндэстэн бол Орос улс, Хятад улсын түүхийн хавсарга биш, биеэ даасан эртний аж ахуй, төр, соёлын уламжлалтай гэснийг нотолсон зүйл л байдаг. Оросын эрдэмтдийн 1993 онд нийтлэгдсэн хамтын бүтээлийг үзэхэд Оросын түрэг судлаач нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный Архангай аймгийн нутаг Хөшөө Цайдамд байдаг түрэгийн рун бичгийн дурсгал зэргийг судлаад Түрэг улс /555-747/, Уйгар улс /747-840/, тэдгээрийн дараах үед "Татар улсууд" гэх Чингэсээс өмнөх монголын түүийн шинэ үе байна гэж нотолжээ /27-н 139-147/. Оросын эрдэмтэн

В.Трепавлов "Нүүдэлчдийн эзэнт улсууд дахь төр ёсны уламжлалууд" өгүүлэлдээ БНМАУ-ын зарим эрдэмтний зарим бүтээл оросоор нийтлэгдснийг үзээд монгол улсын эрдэмтэд монголын төр ёсны уламжлалыг бүр 2200 жилийн тэртээгээс, Хүннү улсаас эхлэдэг тухай тодорхой өгүүлжээ /27-н 169-189/. Гэтэл БНХАУ-ын хэсэг эрдэмтэн тухайлбал "Монгол үндэстний товч түүх" /1988/ номын зохиогчид хятад сурвалж бичгийн мэдээг гуйвуулан, монгол улсаатны түүхийг хятадын түүхийн хавсарга байсан мэт болгосныг дээр өгүүлсэн. Хөх хотод 1991 онд нийтлэгдсэн Чингэсийн тухай БНХАУ-ын эрдэмтдийн бичсэн өгүүлүүдийн эмхтгэл бол монголын төр ёсны уламжлал зөвхөн 1206-1271 оноор хязгаарлагдах мэтээр харуулсан, Монгол угсаатны биеэ даасан түүхийг хятадын түүхийн хавсарга мэт болгосон /34-н 3-892/ зохиол байна. Иймд БНМАУ шинэ үсэг авч хэрэглэсэнтэй холбогдуулан Нууц үгсэл номын зохиогчид дурьдсан зүйл /433-434/ бол БНХАУ-ын төрийн хагас далд стратегийн бодлого, хэсэг хятад түүхчинд холбогдоно. Монголын утга зохиол судлаач, дэлхийд нэрд гарсан эрдэмтэн Ц.Дамдинсүрэн оросын кирил үсгийн үндсэн дээр ө, ү үсэг нэмэн шинэ монгол бичиг зохиосон нь БНМАУ-ын хөгжлийн бодит шаардлагыг хангасан улс төр, эдийн засаг, соёл, хүн ам зүйн гүн гүнзгий ач холбогдол, үр дүнтэй бүтээлч үйл ажиллагаа болсон, болсоор байгаа, болсоор байх ёстойг монголын утга зохиол, бичгийн түүхийн судлалаар дэлхийд нэрд гарсан эрдэмтэд болох доктор, профессор академик А.Лувсандэндэв /"Бодлын солбицол", сонин, 1991.8.3. №3/, доктор профессор Д.Ёндон /"Бодлын солбицол", 1992.2.22-28, №6/, доктор, төрийн шагналт зохиолч Ш.Гаадамба /"Улаанбаатар", 1993.3.19. №44/ нар шинжлэх ухааны үүднээс нотлон харуулжээ. Шинэ бичиг хэрэглэснээр БНМАУ-ын боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжил түргэсэн, далайцтай болсон нь албан ёсны тоо баримтаас тодорхой /4-н 106-116/, Ану-ын "Ньюсуик" сэтгүүлд 1992.3.9-нд Монгол улсын талаар нийтлэгдсэн өгүүлэлд "Гэхдээ энэ орны хүн ам залуу, 98 хувь нь бичиг үсэг мэддэг зэрэг давуу талтай...Саяхан улсын өмчинд байсан дэлгүүрийг хувьдаа авсан 32 настай Дэлгэрням "Бид

өөрсдийн толгой гартай улс, тэгэхээр өнөөгийн нөхцөлд зохицон хөдлөх хэрэгтэй" хэмээн ярив. Коммунизмын далан жилийн дараа ийнхүү сэтгэдэг хүмүүстэй үлдсэн энэ орон ямар азтай вэ" гэж бодит үнэн байдлын тухай бичсэн "Ардын эрх" 1992.5.13. №62.

Нууц үгсэл номын зохиогчид 9-р бүлгийн 3-р зүйлийн 2-р дэд зүйлээ "Монгол, Хятадын харилцааны бал сар" гэж /442-443/ гарчиглаад 1949 онд БНХАУ байгуулагдсанаас хойш 1960 хэдэн он хүртэл БНМАУ, БНХАУ найрсаг харилцаа тогтоон ажилласныг зарим тоо баримтаар харуулжээ.

Зохиогчид цааш нь 3-р зүйлийг "Хятадын эсрэг тэргүүн манлай" гэж /443-452/ нэрлээд 1960-аад оноос БНМАУ, БНХАУ-ын хоорондын харилцаа муудаж хурцадсан нь БНМАУ, түүний удирдлага тухайлбал Ю.Цэдэнбалын үйл ажиллагаатай холбоотой байсан мэтээр дурьджээ. Нууц үгсэл номын зохиогчид нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг устган БНХАУ-д нийлүүлэх тухай асуудлыг Мао Цэдун тэргүүтэй БНХАУ-ын удирдлага 1954 онд Зөвлөлтийн удирдлагад тавьж байсныг "Мао Цэдунгийн эцсийн хүчин чармайлт" гэж гарчиг тавин өөрсдөө тодорхой өгүүлснийг /415-416/ дээр дурьдсан. Ингээд БНХАУ-ын удирдлага БНМАУ-ын тусгаар тогтнолыг устгах тухай асуудлыг Зөвлөлтийн удирдлага зөвшөөрөхгүй болохоор төрийн хагас далд стратегийн бодлогоо хэрэгжүүлэх улс төр-дипломат, эдийн засаг, соёл, цэргийн цогцолбор ажил явууллагыг БНМАУ-ын дотоод, гадаадад ил далдаар эрчимтэй явуулсан билээ.

Ахмад зүтгэлтэн Ч.Сүрэнжэв 1957 онд Өвөр Монголын Өөртөө Засах орны 10 жилийн ойн баярт оролцох БНМАУ-ын төлөөлөгчдийг тэргүүлэн очихдоо БНХАУ-ын Засгийн газрын Ерөнхий сайд Чжоу Энълайтай уулзахад: "Дээр үед хятадын хан үндэстэн бусад үндэстэн ястныг олон жил ноёрхож байсан юм. Одоо тэдгээр үндэстэн нарт зохих тусламж үзүүлэх явдал ээлжит зорилтын нэг болов. Энэ талаар манай дарга Мао Цэдуну хэлсэн сургаал бий. Тэдэнд туслаж буй нь хэрэг дээрээ урьд тавьсан өрөө одоо төлж буй хэрэг гэж үзэж байна...Бид Монгол улсад ч ихээхэн өртэй бөгөөд түүнийг төлөх ёстой юм. Манай Мао дарга 1956 оны намар МАХН-ын Төв Хорооны дарга Д.Дамбатай

уулзахдаа манайх Монголд олон жилийн өртэй, түүнийг төлье гэж хэлснийг зүйтэй гэж ХКН үздэг юм" гэжээ /"Бодлын солбицол" сонин, 1993.8.1-15, №31, 32/. БНМАУ-д хятадын ажиллах хүчин олноор нь оруулан өрөө төлнө гэсэн нь Чжоу Энълайн дор дурьдах үгнээс тодорхой байна. Чжоу Энълай цааш нь Ч. Сүрэнжавт хэлэхдээ: "Өмнөговь аймгийн ардуудыг хойш нь нүүлгэж тэнд манай хүмүүсийг оруулан тариа ногоо тариулах бололцоо байж болох уу?" гэж асуухад: "илүүчлэх газар ч байхгүй гэж түс тас" хариулжээ. Ингэхэд БНМАУ-д "туслах хөрөнгө гаргах талаар нэлээд хэцүүхэн байна" гэжээ. Үүнээс үзэхэд БНХАУ-ын удирдагч Мао Цэдун, Чжоу Энълай нар бусад ард түмнийг хятад үндэстэн олон жил ноёрхож байсан өрөө өгнө гэсэн зулгай үгээр ёстой "нэг сумаар хоёр туулай агнах" гэсэн байна. Үүнд: нэг талаар Монголыг Хятад олон жил ноёрхон харьяанд байлгаж байсан мэтээр батлах, нөгөө талаар "өрөө төлөх" нэрээр мэхлэн олон буман хятадыг БНМАУ-д оруулан шууд цусгүй түрэмгийлэл хийх гэж оролдсоор байжээ. Чингээд Ч.Сүрэнжав нартай ярилцах үедээ БНМАУ-д 160 сая төгрөгийн тусламж үзүүлэх болж, улмаар 10000 гаруй хятад ажилчин БНМАУ-д оруулж чадсан юм.

Ю.Цэдэнбал БНМАУ-ын талаар БНХАУ-ын удирдлагаас явуулж байгаа ажил явууллагыг 1981 онд дэлхий дахины өмнө тодорхойлон хэлэхдээ: "Бүгд Найрамдах Хятад Ард Улстай харилцах тухайд бол уг харилцаа муудсан нь манай буруу биш юм. Үүний шалтгаан нь Хятадын эрх баригчид социализмын зарчмыг мушгин гуйвуулж, улс хоорондын хэм хэмжээг балмадаар алдагдуулан, тэдгээрийг их гүрний жанжлах үзэл, айлган сүрдүүлэх, тулган шахах бодлого, үйлдлээр сольсонд оршино. Тэд манай орныг эзлэн түрэмгийлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийг оролдохдоо түүх бодит үнэнийг завхруулж, БНМАУ-ын эсрэг цэрэг дайны бэлтгэлийг хийж байна" гэжээ /19-н 13/. 1980 онд Ю.Цэдэнбал БНМАУ-ын тусгаар тогтнолын эсрэг БНХАУ-аас явуулж байсан зарим гол ажиллагааг тоочин хэлэхдээ БНМАУ-ын тусгаар тогтнолыг устгах тухай асуудлыг Мао Цэдун 1936, 1949, 1954, 1964 онд ярьж тавьж байсан, 1978 онд БНХАУд хэвлэгдсэн хятадын дунд сургуулийн сурах

бичгийн газрын зурагт БНМАУ-ын нутгийг БНХАУ-ын нутагт оруулсан, 1970-аад оны эхээр халдварт өвчтэй олон түмэн зээрийг БНМАУ-ын Сүхбаатар, Дорнод аймгийн нутагт оруулсан, Хятадын иргэд хордуулсан үр тариа, хүнсний бүтээгдэхүүнийг БНМАУ-д төмөр замаар оруулж байсныг дурьдсан /"Үнэн" сонин, 1980.10.2. №237/ билээ. Хятад цагаачид БНМАУ-ын эсрэг элдэв хорлон бусниулах ажил явуулсан учир тус улсын нутгаас хөөгдөж байсан тухай мэдээ сонин, хэвлэлд 1970-1980-аад онд нийтлэгдэн зарлагдаж байв. АНУ-ын Дээд шүүхийн гишүүн В.О.Дуглас БНМАУ-д албан ёсоор айлчилсан тухай тэмдэглэхдээ: "Гэхдээ Орос, Хятад хоёрын хооронд хүчний тэмцэл үргэлжилсээр байна. Энэ хоёр их гүрнээр бүрэн хүрээлэгдсэн Монгол нь тэдгээрийн өрсөлдөөний объект болсоор байна. Орос бол Хятадын сая сая хүмүүсийг хилээсээ хөндий байлахыг хүсч байна. Хятад бол эзлэн авах хэрэгцээтэй байна гэж /39-н 289/ БНХАУ-ын эзлэн түрэмгийлэх бодлогыг илчилсэн юм. БНМАУ, Монголын ард түмэн олон мянган жилийн түүхээр заягдсан эрх чөлөө тусгаар тогтнолоо хамгаалах хууль ёсны эрхтэй нь мэдээж.

БНХАУ-ын төрийн бодлогын захиалагаар бичигдсэн нөгөө "Монгол үндэстний товч түүх" номд хэрэглэгдсэн "хаант Оросын эзэрхэг түрэмгийтний урт хугацааны ухуулга ба удирдаж тоглосон байдал" гэх үг хэллэгийг /10-н 588/ энэ Нууц үгсэл номонд дуриан хэрэглэж, их далайцтай болгожээ. Чин үнэнийг хэлбэл оросууд монголчуудын дотор ухуулга, ятгалга хийх боломж бараг байхгүй, харин хятадууд хязгааргүй боломжтой байсан, түүнийгээ дээд зэргээр ашиглаж байсан.

Зохиолч Л.Түдэв "Үнэн" сонинд /1991.10.2. №127/ нийтлүүлсэн Есөн луугийн шүтээн. Дорнодын салхи "Тэмдэглэлийн Луугийн садан төрөлүүд" зүйлд: "Манай Өргөө хотод ч саяхан болтол хятад шийяанз гэдэг цан хэнгрэг, бишгүүр лимбэ цаг үргэлж хангинаж, луйзайхуай, хуйцай, хуйбунгийн үнэр хамар цоргиж байдаг нэгэн хөл ихтэй газар байсан нь одоо үгүй болж ХИД буюу хүнсний их дэлгүүр, оёдлын үйлдвэр, урт цагаан байшинт үйлчилгээний газрууд нэгэнт буй болжээ. Их хятадын өргөн чөлөө байсан

нь үгүй болж харин ноднингоос тэр дээр үеийг санагдуулах ганц нэг сэхээвч дэрэвгэр оройт модон хаалга зэргийг босгож байна. Дээр үед тухайлбал Богд хаант Монгол улсыг татан буулгах явуулга хүчтэй болж байх цагт олноо өргөгдсөн есдүгээр онд бас тэр хавьцаа Наран улс Нанхиад улс хоёр хувь нийлүүлж банкны газар байгуулжээ. Тийнхүү хувь нийлүүлсэн банкныхаа газрыг Житоу Жанхан гэж нэрлээд тэнд /Баруун дамнуурчны өмнө этгээдэд/ хоёр давхар байшин, сүм сэлтийг байгуулж, Хятад газраас Үзэсгэлэнт сайхан хүүхэн шалгаруулж авчирчээ. Тийнхүү Өргөө хотноо албан ёсны янханы буюу дууч эмсийн газар байгуулсан. Яагаад дууч эмс гэсэн юм бэ гэвэл тэнд монгол ноёдыг урьж хоол зоог барьж, будаалаг хийж нөгөөх хүүхнүүдээр дуу дуулуулан ноёдыг эрхлүүлдэг байжээ. Дууч эмсийг Хятад газар шалгаруулж хятад хүүхэн нэгэн мянгийг авчирсан ажээ. Хэрэв монгол ноёдод тэдний хэн нэг нь таалагдвал эхнэр нь болох ёстой. Тэгвэл урамшуулан хөхүүлэх тусгай болзолтой байсан юм гэдэг. Эхлээд монгол ноёд тэнд өдөр шөнөгүй найрлаж улс орныхоо ажлыг таг мартсан ажээ...Богд хаант төр ч төдөлгүй мөхжээ. Тэгэхэд Рибин /Житоу/-Жанхан банкны дууч эмсээс төрсөн хүүхдүүд одоо далаад настай ч бас царигтай байгаа ажээ. Эх нутагтаа зарим нь буцсан ч энэ газар үлдсэн нь цөөнгүй" гэж бичжээ. "Дэн Сяопин 1969 оны 1-2-р сард АНУ-д очихдоо Зөвлөлт Холбоот Улсыг өөрөөр хэлбэл "Таймс" сэтгүүлд өгсөн сурвалжлагадаа өөрөө хэлснээр "цагаан баавгайг номхтгохын" тул АНУ, Япон, баруун Европыг оролцуулан "Олон улсын фронт" байгуулахыг уриалсан" байна /22-н 227/. Дэн Сяопин мэтийн том хүмүүс бол том гүрний төрийн зүтгэлтэн, өвгөн хүний намбагүй, их хан үндэстний дээрэнгүй үзэлтэн байдаг болохоороо Зөвлөлтийн бүх ард түмнийг доромжлон дайрч занаж байжээ. Ийм хүмүүс монголчууд мэтийн жижиг ард түмнийг огтхон ч тоохгүй нь мэдээж.

Нууц үгсэл номд БНМАУ-д гарсан баруунтан, хувьсгалын эсргүү явдалтай хоолбогдсон цааш нягтлууштай зарим баримт дурьдсан байна. "Дамбадорж бол Улиастайн феодалын гэр бүлээс гаралтай хүн. Тэр бага наснаасаа хятадын "дөрвөн ном", "таван ном" дахь

күнзийн сурталын нөлөөнд орсны зэрэгцээ бурхны шашин шүтдэг хүн" байсан /284/ гэжээ.

1921 оны 7-р сард Монгол Ардын хувьсгал ялсны дараа Хятадын цэргийн эрхтэн Чжан Цзолинь Харбинд яаралтай зөвлөлгөөн хийж Монголыг цэргээр довтолоё гэж байсан, Гадаад Монгол тусгаар тогтнолоо зарласантай холбогдуулан хэлэхдээ "би үүнийг огт мартахгүй гэж өшин заналхийлж байсан!", уг зөвлөлгөөнд Гадаад Монголын феодалын төлөөлөгчид оролцсон тухай дурьдсан /218-219/ байна. Бодоо 1922 оны 5-р сард Харбинд нууцаар очиж Чжан Цзолиньтай уулзан ярилцаж байсан, цэргийн тусламж гуйсан тухай дурьджээ /228-234/. "Ардын хувьсгалт нам улаан Оросоос тусламж гуйсан нь зөв болсон. Харин дотоод бодлогдоо Улаан Оросыг дууриах гэж байгаа нь буруу байна" гэж нэг дотно хүндээ Бодоо хэлж байсан, албан тушаалаасаа чөлөөлөхийг хүсэж хоёр удаа өргөдөл өгөн 1922 оны 1-р сарын 7-нд том албан тушаалаасаа Бодоо чөлөөлөгдсөн, Зөвлөлт Орос улсад суух элчин сайдаар томилоход Бодоо татгалзаад хөдөө гаран ажилгүй байсан /3-н 36.44, 49/ нь Нууц үгсэл номын зохиогчдын дурьдсан Бодоогийн үйл явдалтай яг тохирч байна.

Югзэр хутагт, Манзшир хутагт, Дэлэв хутагт нар оролцсон "38-ын хэрэг"-т холбогдсон хүмүүс Нанжин дахь Гоминданы засгийн газраас тусламж гуйсан зэргийн тухай Нууц үгсэл номын зохиогчид дурьджээ /302-305/.

Хятадын Засгийн газар, Хятадын харгис хүчин нь БНМАУ-ын худалдаа, эдийн засагт ноёрхолоо хэвээр хадгалах, БНМАУ-ын тусгаар тогтнолыг устган Хятадын нэг муж болгохын тул бүр 1921 оноос эхлэн цэргийн хүчээр түрэмгийлэхээр завдах, БНМАУ-ын дотор "тагнуулын байгууллага байгуулах", "элдэв хорт цуурхал тараан ард олныг үймүүлэхийг оролдох" зэрэг тагнах, бусниулах ажлыг зохион явуулсаар байжээ. Жишээлбэл 1924 онд Хятадын цэргийн төлөөлөгч генерал Бан Ишаны удирдлага туслалцаатайгаар Улаанбаатарт машины гарааш, буудал байгуулж байсан Ли Хайпин гэдэг хятад хүн 1925-1926 онд Японы тагнуулын бүлгийг Япон Кузимагийн дэмжлэгтэйгээр Улаанбаатарт байгуулсан, БНМАУ-д 1929 онд ирсэн Хятадын худалдааны зөвлөх, хувь нийлүүлсэн Сен-тун нийгэмлэгийн

нарийн бичгийн дарга Ли Вайхуай тагнуулын мэдээ боловсруулж байсан, БНМАУ-д тагнуул хийсэн хэргээр 25 хятад иргэн ял шийтгүүлсэн, БНМАУ-тай хил залгасан Өвөр Монголын нутагт хил хамгаалах халхавчаар Японы тагнуулын сургуулиуд 1937 оноос байгуулагдсан, Японы тагнуулын хэрэгт 1945 онд шийтгүүлсэн Пунцагийн Чүлтэм /Лувсанчүлтэм/ 1945 оны 10-р сард өгсөн мэдүүдэг зэрэг асар олон түүхэн баримт дурьдаж болно /16-ын 27, 31, 35, 43, 50/.

БНМАУ-ын Дотоодыг хамгаалах газрын орлогч дарга байсан Цэрэнгийн Гиваапил хилс хэрэгт холбогдон 1934 онд ЗХУ-д цөллөгөнд байхдаа нам, төрийн удирдлагад хандан бичихдээ: "зарим удирдагч ба нөхөр Намсрай нараас хэрэгт анхааран үзэхгүй харин энэ хэргээ хүлээв, дахин дөчнөөн хүн нэмэгдэв хэмээн баярлах байдалтай болж уг хэргийг урвуулан хувьсгалын зам шугамд гажуудуулж, хувийн нэр ашиг, өшөө хорслын зүгт урвуулан ашигласан бөгөөд жишээлбэл нөхөр Гэндэнгээс эл хэрэгт Жигжиджавыг заавал холбогдуулах ёстой. Хэрэв тэр хэдий /нас/ барсан боловч түүний нэрийг лав баримттайгаар холбогдуулж чадах ахул түүнээс олох ашиг туйлын гүнзгий болмой. Энэ нь хэрэг бүрд Холбоот Улс хэмээн хашгирагчдыг түүний гэдрэг эсэргүү болгож мөнөө сайнаар үздэг оросуудад бэлэглэх зохистой хариу болж чадна. Ер ганц Жигжиджаваар зогсохгүй бусад энэ мэтийн толгой дээгүүр довтлогчдыг боловч нэр сүрийг бууруулах хэрэгтэй" гэж байсныг илчилсэн байна /"Үнэн" сонин, 1993.9.15. №83/. Ц.Гиваапилийн захидлын агуулгыг 1938 онд БНМАУ-аас оргон Японд зугатан очсон Бямбын тэмдэглэлтэй өнгөцхөн тулгаж үзэхэд 1930 хэдэн онд "Монголчууд биеэ даасан Гадаад Монголын төлөө" хөдөлгөөн гэх Зөвлөлтийн эсрэг үзлийг дотоод гадаадын зохих хүчин бий болгосон нь маргаангүй байна. (21 -н 14, 16, 21)

БНМАУ 1920-1930 оноор барахгүй, ер нь өнгөрсөн 70 жилд эсхүл ЗХУ-ыг түшиглэн тусгаар тогтнолоо хэвээр байлгах, эсхүл тусгаар тогтнолоо алдан Хятад улсын харьяат болох ердөө хоёрхон замтай, хоёрхон боломжтой байсан нь түүхэн бодит байдал мөн. Ингээд хувьгалын эсэргүү дотоод, гадаадын хүчнүүд нь монголчуудын үндэсний

өөрийн ухамсар, өөрийн мэдрэмжийг гэнэдүүлэн овжин ашиглаж, олон мянган монгол хүнийг өөрсдийнх нь гараар хядуулж чаджээ. БНМАУ дахь улс төрийн хэлмэгдэл бол уг асуудлыг төрийн ноён нурууны үүднээс маш ухаалгаар авч үзэхгүй бол одоогийн Монгол улсын төрийн тусгаар тогтнолыг устган, яваандаа монгол үндэстнийг мөхөөх аюултай туйлын эмзэг асуудал мөн. Дашрамд дурьдахад үеэ өнгөрүүлсэн феодалын байгуулалыг устгасан, БНМАУ-ын өнгөрсөн 70 жилийн түүхэн хөгжил бол хүн төрөлхтний түүхэн хөгжлийн жам ёсоор явагдсан ерийн бодит түүхэн процесс мөн. Энэ хугацаанд ноцтой алдаа дутагдал, хэлмэгдэл гарсан нь түүхэн үнэн мөн. Энэ өнгөрсөн 70 жилд дэлхийн бусад бүх оронд ноцтой алдаа, дутагдал хэлмэгдэл гарсан нь бас түүхэн үнэн мөн. Фашизм, дэлхийн хоёрдугаар дайн, дэлхийн колонийн систем, түүний задрал, уналт, арьсны үзэл, хятад дахь "соёлын хувьсгал", хүйтэн дайн, тэдгээртэй холбогдсон олон олон сая хүнийг хэлмэгдүүлсэн том, жижиг үйл явдал дэлхийн улс, орон бүрт гарсан шүү дээ.

Эцэст нь тэмдэглэхэд Нууц үгсэл номын зохиогчид нь Монгол улсын түүхэнд сөрөг үүрэг гүйцэтгэсэн Өндөр гэгээн Занабазар /18/, Бадамдорж /139/ нарыг магтан өргөмжилж, харин Монгол улсын тусгаар тогтнолын төлөө тэмцсэн Галданбошигт /18/, Монголын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл ялахад том хувь нэмэр оруулсан Богд, Ханддорж /126/, Монголын ардын төрийг үндэслэн байгуулагчдын нэг Д.Сүхбаатар /418/, БНМАУ-ын төрийн гарамгай зүтгэлтэн Х.Чойбалсан (264, 418) Ю.Цэдэнбал /434/ гэх мэтийн эх оронч хүмүүсийг өөрсдийн ба Тайваны хятадын үгээр "урвагч" гэх зэргээр доромжлож зүхжээ.

"Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц үгсэл" гэдэг БНХАУ-ын төрийн хагас далд стратегийн бодлогыг хэрэгжүүлж дуусгах ажиллагаанд БНХАУ-ын ажил хэрэгч хүмүүс, худалдаа, үйлдвэрийн хүмүүсийг өдөөн дайчилсан албан ёсны номын гол агуулга, зорилго ерөнхийдөө ийм байна. Ийм учир энэ номтой холбогдон манай Монгол улсын дотор ихээхэн шуугиан дэгдэж, түүний тухай танилцуулга "Ил товчоо" /1993.6.1-10. №14/, "Ардын эрх" /1993.6.11.

№92/, "Үнэн" /1993.6.16. №60/ зэрэг сонинд, товч шүүмж  
"Үнэн" /1993.9.15. №83/ сонинд нийтлэгджээ.

Энэ ном бол нэг талаар хятад хүмүүсийг сэтгэл судлалын ухааны үүднээс дайчилсан учир, нөгөө талаар неопанмонголизм гэдэг монголчуудыг монголчуудаар нь хөнөөлгөх хүчирхэг хэрэгслийг ашиглах гэсэн учир Монгол улсын хувьд, манай монголын ард түмний хувьд мөхөх, сэхэхийн нэгийг үзэх том шалгалт, эцсийн том сорилт болж байна. Монгол улсын монгол үндэстний эрүүл саруул ухаан л, бүтээлч хөдөлмөр, үйл ажиллагаа л энэ эцсийн том шалгалт, сорилтыг давж чадах нь эргэлзээгүй.

### НОМ ЗҮЙ

1. Ар Монгол дахь Хятадын худалдаа-мөнгө хүүлэл. 31751-1911/. Баримт бичгүүд. Улаанбаатар, 1988.
2. Базарын Санжмятав. Гурван улсын Хиагтын гэрээний тухай түүхэн үгнэн. Улаанбаатар, 1991.
3. Л.Бат-очир. Түүхэн бие хүн, улс төрийн хөрөг. Бодоо сайд. Улаанбаатар, 1991.
4. БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд /1921-1991/. Улаанбаатар, 1991 /монгол, англи хэлээр/
5. БНМАУ-ын түүх. Дэд боть, 1604-1917. Улаанбаатар, 1968.
6. Р.Гүр. Хүн амын эрүүл мэндийн байдалд хийсэн статистик судалгаа. Улаанбаатар, 1967.
7. Гэрэл сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. Улаанбаатар, 1992.
8. Ч.Далай. Юан гүрний үеийн Монгол. Улаанбаатар, 1973.
9. Монгол улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл. Улаанбаатар, 1993.
10. Монгол үндэстний товч түүх. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, Хөх хот, 1988 /худам монголоор/.

11. Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгүүдийн эмхтгэл. /1900-1914/. Улаанбаатар, 1982.
12. Г.Сүхбаатар. Монгол-Нирун улс /330-555/. Улаанбаатар, 1992.
13. Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. Улаанбаатар, 1980.
14. Тегеран. Ялта. Потсдам. Баримт бичгийн эмхтгэл. Нэмэлт оруулсан хоёрдугаар хэвлэл. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар, 1973.
15. Тусгаар тогтнолын мөрөөдөл. /Япончууд Монголын тухай/. Улаанбаатар, 1991.
16. Түмний хараанаас мултраагүй. Соёмбо хэвлэлийн газар. Улаанбаатар, 1991.
17. Түүхийг гуйвуулах маоист аргыг шүүмжлэх нь. Улаанбаатар, 1981.
18. Халх журам. Доронатив найруулан тайлбарлав. Өвөр монголын сурган хүмүүжлийн хороо. Шилийн гол анмгийн Хэвлэх үйлдвэр. 1989 /худам монголоор/.
19. Ю.Цэдэнбал. МАХН-ын 18-р их хуралд тавьсан намын төв хорооны тайлан, ойрын жилүүдийн зорилт. Улаанбаатар, 1981.
20. Чулууны Далай. Монголын түүх. /1260-1388/. Гудгаар дэвтэр. Улаанбаатар, 1992.
21. Японд зугтаж гарсан Бямба. "Соёмбо" хэвлэлийн газар. Улаанбаатар, 1991.
22. Денеш Барач. Дэн Сяопин. Перевод с венгерского В.С.Иванова. Москва, "Международные отношения". 1989.
23. Диалог Сталина с МаоЦзэдуном-жур. "Проблемы дальнего Востока", 1990. №06.с.86.
24. Кому принадлежит суверенитет над Тибетом и как в Тибете обстоит дело с правами человека. Пресс-канцлэрия Госсовета КНР. Сентябрь 1992. Пекин.
25. Маоистская фальсификация истории МНР и историческая правда. Улан-батор, 1980.

26. Советско-китайские отношения 1917-1957 гг. Москва, 1957.
27. Mongolica. К 750 летию "Сокровенного сказания". Издательская фирма "Восточная литература". Москва, 1993.
28. Гуаньтан цзилинь /Ван Говэйи зохиолын түүвэр/. 3-р дэвтэр, бээжин, 1959 /хятадаар/.
29. Жоужань цзыляо цзилу /Нируны тухай хэрэглэгдэхүүний эмхтгэл/. Бээжин, 1962. /хятадаар/.
30. Линь Гань Бянь. Сюнну шиляо хуйбянь. Шан, Ся Бянь /Линь Гань эмхтгэв/. Хүннүгийн түүхийн хэрэглэгдэхүүний эмсгэл. 1,2-р боть, Бээжин, 1988 /хятадаар/.
31. Ляо ши. Соинь байна бэнь эршисы ши /Ляо-гийн түүх. Агшаан нягталсан 24 түүх/. Шан-у иньшу гуань хэвлэл. Шанхай, 1958. /хятадаар/
32. Нэймэнгуда цындянь /Өвөр монголын том толь/. Нэймэнгу жэньминь чубань шэ. Хөх хот, 1991. /хятадаар/.
33. Чжунго лидай гэцзу цзинянь бяо. Линь Гань, Лю Цзюньлин Хэбянь /Хятадын түүхэн дэх үндэстнүүдийн оны хүснэгт. Линь Гань, Лю Цзюньлин нар хамтран эмхтгэв/. Хөх хот, 1980. /хятадаар/.
34. Чэнцзисы хань яньцзювэньцзи /Чингис хааны судлалын түүвэр/. Хөх хот, 1991. /хятадаар/
35. Edgar Snow. Red Star over China. Sixth Edition. Grove Press, Inc. New York. 1981
36. The Han hordes, Inner Mongolians a minority in their own homeland - "Eastern Economic Review" 9 April 1992, pp 18-19
37. The maoist falsification of the history of the Mongolian People's Republic and the historical truth. Ulan-Bator. 1981.
38. Stanley Fischer, Rudiger Dornbusch, Richard Schmalensee. Economic Second Edition. London, 1988.
39. William O. Douglas. Journey to Outer Mongolia, - "National Geographic Magazine". March 1962. Vol. 121, No.3. pp. 289 - 345.
40. A. Wittfogel, Feng Chiasheng. History of Chinese Society Liao ( 907 - 1125 ). Philadelphia. 1949.